

УЛС ТӨР

МАНАЙ УЛСАД НИЙТДЭЭ
188974 ТӨРИЙН АЛБАН ХААГЧ
БАЙГАА ГЭВ

II нүүрт

ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

Г.ЭНХТҮВШИН: ДОРНОГОВЬ МОНГОЛ
УЛСЫН ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ХУВЬ
НЭМРЭЭ ОРУУЛНА

V нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр +27
Шөнө +7

ҮЗЭЛ БОДОЛ

Дулмаагийн ӨРХИЙН ОРЛОГО өссөн шалтгаан юу байв

Дугаарын **60** мөр

Зургадугаар сарын 1-нийг
“Автомашингүй өдөр”
болгоё

Б.СУМБЯА

Хүүхэд бүрийн хүснэгтэд зургадугаар сарын 1 асуу. Энэ өдөр л хүүхдүүд эцэг, эхийнхээ гараас хөтлөн төв талбайг зорьж, тэнд зохион байгуулагдаж буй хэдхэн үйл ажиллагаанд оролцон түрүүвчнийхээ хэмжээгээр хүүхдүүд баярлуулдаг. Гэвч, автозамд түгжрэл үүсч, нялх хүүхдүүд машинд дайруулах, шүргүүлэх тохиолдол олон гардаг нь нууц биш. Өнгөрөгч 2016 оны “Хүүхдийн эрхийн хамгаалах өдөр”-өөр гэхэд нэг хүүхэд зам тээврийн осолд өртөн амьсгал хураасан харамсалтай хэрэг гарч байсан юм. Гэмтэж бэртсэн хүүхдийн тоог оруулахгүйгээр ийм байна.



Грэм зурвал: ГАРЛУУЖИН

Үргэлжлэл нь III нүүрт

Төгсгөл нь III нүүрт

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Т.АРИУНБААТАР: ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАМГИЙН АШИГТАЙ ХУВИЛБАРААР АЖИЛЛУУЛНА

Х.АРИУНГЭРЭЛ

ЗТХЯ-ны харьяа Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал Т.Ариунбаатартай ярилцлаа.

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ байгуулагдаад таван жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд танай байгууллага ямар үйл ажиллагаа явуулав, байгууллагын гол зорилго чиглэл юу вэ?

Манай төв хувийн болон улсын төмөр замын байгууллагуудыг тэгш эрхтэйгээр, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамгийн ашигтай хувилбараар ажиллуулах

зорилготой байгууллага. Тэгш эрхтэйгээр өмчийн хэлбэр харгалзахгүй ажиллуулах гэдэг нь хувийн болон улсын төмөр замын байгууллагууд нэг нэгнийхээ галт тэрэгний хөдөлгөөн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар саад болохгүйгээр, нэг нэгнийхээ эрх ашгийг хөндөхгүйгээр үйл ажиллагааг нь зохицуулахыг хэлнэ. Ерөө өртөөгөөр жишээ авъя л даа. Дамжин өнгөрүүлэх ачааны хэмжээ эрчимтэй нэмэгддээ гэж бодоход Ерөө өртөөний ачааг цаг алдалгүй татаж авч чадах уу, үгүй юу гэдэг эргэлзээтэй. Хэн түрүүлж зах зээлд хүрсэн нь үнэд ордог учраас аль нэг нь давуу байдлаа ашиглан бусдын ачаа тээвэрт саад учруулахыг үгүйсгэх аргагүй.

Тиймээс аль компанийн явуулсан ачаа хэний суурь бүтэц дээгүүр, хэр хэмжээний хатуу зурмагийн дагуу дамжин гарч байна вэ гэдгийг хянах нь чухал. Бид үүнийг зохицуулах үүрэгтэй. Уул уурхайн болон бусад үйлдвэрийн төмөр замууд нэмэгдэх нь тодорхой. Ингэхээр хэн түрүүлж хөдөлсөн нь зах зээлд амжилт олно. Өөрийнхөө ачаа түлхүү явуулах зэрэг асуудал үүснэ. Иймд манай төв өдөрт хэдэн галт тэрэг, транзит тээвэр, стратегийн болон нүүрсний тээвэр, арилжааны галт тэргийг хувийн болон улсын төмөр замуудаар хэрхэн тэгш эрхтэйгээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дамжин өнгөрүүлэх зохицуулалтыг хийж өгнө гэсэн үг.

Төгсгөл нь IV нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Пак Гын Хөд холбогдох хэргийн шүүх хурал боллоо

Б.ДАВАА

“Тэр хууль дүрмийг үл ойшоосон”, “Та нар таамаглал төдийхөнөөр яллах дүгнэлт үйлдсэн”. Энэ бол өчигдөр БНСУ-ын нийслэл Сөүл хотын төв шүүхэд болсон Ерөнхийлөгч асан Пак Гын Хөд холбогдох хэргийг шүүх хурлын үеэр гарсан маргаан, мэтгэлцээний онцлох дүр төрх. Тус улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгч асан Пакийг “Самсунг”, “Лотте” зэрэг томоохон байгууллагаас авлига авсан гэх мэт нийт 18 хэрэгт буруутган ялласан. Улмаар түүнийг шүүх анхны хурал өчигдөр болсон юм. Энэ үеэр прокурорууд болон өмгөөлөгчдийн хооронд дээр дурьдсан ширүүн мэтгэлцээн өрнөжээ. Прокурорууд шүүх хурлын эхэнд “Сэжигтэн Пак Гын Хе найз Чой Сун Шилтэй



үгсэн хуйвалдаж, төрийн албанд ямар ч хамааралгүй хүнд нууцны зэрэглэлтэй материалыг задруулсан. Төрийн албаны хууль дүрмийг үл ойшоож, Үндэсний тусгаар тогтнол, хуулийг уландаа гишгэсэн” хэмээн буруутгасан байна. Мөн тэд “Пак дээрх томоохон корпорациудын удирдлагуудтай нийтдээ гурван удаа уулзаж, Чойгийн охин морины уралдааны

тамирчин Чён Юрад дэмжлэг үзүүлэхийг шаардсан. Үүний дагуу Самсунгийн удирдлагууд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зорилгоор их хэмжээний мөнгөн дүн бүхий дэмжлэг үзүүлж байсан нь илэрсэн” гэдгийг тодотгож байжээ. Харин Пакийн өмгөөлөгчид “Таамаг, төсөөллөрөө яллахыг оролдож байна” хэмээн эсэргүүцэж байсан аж. Тэдний тухайд “Хэвлэл мэдээлэлээр гарсан нийтлэлийг баримт болгон ашиглаж байх юм. БНСУ-ын прокурорууд хэзээнээс нийтлэл, мэдээллийг эрүүгийн хэргийн нотлох баримтад тооцдог болсныг нь асуумаар байна” хэмээн мэтгэлцэж байжээ. Хэргийг ирэх аравдугаар сар гэхэд эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэ мэт маргаан мэтгэлцээн цаашид ч үргэлжилсээр байх хандлагатай байна.

HUNNU AIR
Wings of Mongolia

Оюу Толгой компанийн 2016 оны “Шилдгийн шилдэг ханган нийлүүлэгч” Хүннү Эйр компаниас Монгол Улсад Нисэх Хүчин үүсч хөгжсөний 92 жилийн ойн баярын мэнд хүргэе.

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2408.00	2422.00	ФУНТ	3087.00	3181.00	АМ.ДОЛЛАР	2410.00	2420.00
ЕВРО	2679.00	2747.00	РУБЛЬ	41.70	43.80	ЕВРО	2691.00	2741.00
ИЕН	21.58	21.89	ЮАНЬ	348.50	352.40	ИЕН	21.51	21.95
						ФУНТ	3108.00	3164.00
						РУБЛЬ	41.52	43.96
						ЮАНЬ	349.00	352.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

МАНАЙ УЛСАД НИЙТДЭЭ 188974 ТӨРИЙН АЛБАН ХААГЧ БАЙГАА ГЭВ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ТОГТОХ

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны өчигдрийн хуралдаанаар хоёр хуулийн төсөл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны тайланг сонслоо. Хуралдааны эхэнд УИХ-ын гишүүн, БОАЖ-ын сайд Д.Оюунхорлоос өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэв. Энэхүү асуудлыг Д.Оюунхорол гишүүн өргөн барьсан шалтгаан нь Үндсэн хуулийн санал асуулгыг Ерөнхийлөгчийн сонгуультай хамт явуулахаас үүдэлтэй юм. Тус хуульд санал асуулга явуулах хугацааг 65 хоногийн өмнө зарлана гэж тусгасан. Гэтэл Ерөнхийлөгчийн сонгууль болоход ганцхан сарын хугацаа үлдсэн учраас хугацааг наашлуулах өөрчлөлт оруулахаар болсон билээ. Хэрвээ Үндсэн хуулиа өөрчлөх эрх санал асуулгыг Ерөнхийлөгчийн сонгуультай хамт хийвэл 30 тэрбум төгрөг хэмнэнэ гэж үзэв. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн анхны хэлэлцүүлгийг хийх үеэр УИХ-ын гишүүн Ж.Батзандан Ерөнхийлөгчийн сонгууль дөхсөн учраас Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг ийм давчуу

байдлаар хэлэлцэх шаардлага байгаа эсэхийг тодрууллаа.

Гишүүний асуулгад байнгын хорооны дарга Н.Энхболд “Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаар Ерөнхийлөгчийн сонгуультай хамтатган ард нийтийн санал асуулга явуулах цаг хугацааны боломж хомс байгаа нь үнэн. Гэхдээ энэ хуулийг батлаад явахад буруу зүйл байхгүй. Иймээс хуулийн төслийг энэ байдлаар нь батлаад дараа дараагийн шатанд шийдвэрлэх асуудалдаа анхаараад явах нь зүйтэй байна” гэсэн санал хэллээ. Улмаар хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх нь анхны хэлэлцүүлэгт шилжүүлэх нь зөв гэж үзсэн юм. Хуралдаанаар үргэлжлүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг сонсов. Энэ

талаар Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо танилцуулга хийсэн юм.

Төрийн албаны зөвлөлийн даргын танилцуулгаас үзэхэд одоогоор манай улсад нийтдээ 188974 төрийн албан хаагч байгаагаас 3032 нь төрийн улс төрийн, 18960 нь төрийн захиргааны, 36949 нь буюу 19.55 хувь нь төрийн тусгай, 130033 нь буюу 68.82 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагчид байгаа аж. Төрийн захиргааны байгууллагуудын 68 зүйн хороодоос ирүүлсэн мэдээгээр өнгөрсөн онд нийт 193 68 зүйн зөрчил бүртгэгдсэнээс төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой 19, гүйцэтгэх албан хаагчтай холбоотой 174 68 зүйн зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оньхтой харьцуулахад 5.4

хувиар буурсан үзүүлэлттэй юм байна.

Харин 68 зүйн зөрчлийг анх удаа гаргасан 166 албан хаагч байгаа бол 27 албан хаагч нь давтан гаргажээ. Танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гарч буй зөрчил дутагдлыг засаж арилгах, ажил эрчимжүүлэх чиглэлээр Байнгын хорооноос тогтоол гаргаж, Төрийн албаны зөвлөлд тодорхой үүрэг чиглэл өгөхөөр тогтлоо. Хуралдааны төгсгөлд “бусад” гэсэн хэсэгт Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах УИХ-ын тогтоолыг хэлэлцэн дэмжсэн юм. Өөрөөр хэлбэл,

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан бүх нийтийн санал асуулгын дүнг ажлын хэсэг наймдугаар сарын 25 гэхэд УИХ-д өргөн барихыг тусгажээ. Анх 1991 онд Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулж явуулах үед Улсын Бага Хурлаас ийм тогтоол гаргаж байжээ. Мөн БОХХАА-н байнгын

хороо хуралдаж Малын генетикийн төлөөлөл болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн юм. Эдгээр хуулийн төслийг баталснаар малын удмын санг эрүүлжүүлэх, мал эмнэлгийн босоо тогтолцоог бий болгосноор дампуурахад хүрээд буй Мал эмнэлгийн салбарыг хөл дээр нь босгоно хэмээн хууль санаачлагчид онцолсон юм.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ц.Мөнх-Оргил: Буцалтгүй тусламжийг юунд зарцуулахаа яриагүй байна

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил өчигдөр цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Тодруулбал, саяхан БНХАУ-д албан ёсны айлчлал хийгээд ирсэн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын ажлын айлчлалын үр дүн болон “Нэг бүс нэг зам” олон улсын чарууга уулзалтаас манай улсад ямар үр өгөөж орж ирэх, Хятад улсаас өгөх хоёр тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, ОУВС-ийн тэргүүнтэй хийсэн түүний уулзалт ямар үр дүнтэй байсан талаарх асуудлыг хөндлөө. БНХАУ-ын дарга Си Зиньпиний санаачилсан “Нэг бүс зам” олон улсын чуулга уулзалтад 130 гаруй орны 1500 гаруй төлөөлөгч дэлхийн томоохон улс орны төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүнүүд оролцжээ. Өмнөд хөрш энэ хөтөлбөрийг анх 2013 онд гаргаж ирсэн бөгөөд БНХАУ дэд бүтэцэр холбогдох санал гаргахаас гадна хятад улс эдийн

засгийн бүтцийн шинэчлэлд шилжиж байгаа гэдгээрээ ач холбогдолтой. Тиймдээ ч Монгол Улсын хувьд энэ том хөтөлбөрөөс хожих учиртай. Тэгвэл энэ талаар Ц.Мөнх-Оргил сайд “Хоёр улсын хооронд хүмүүшлэлийн зөвлөл байгуулахаар тохирлоо. Өмнөд хөрш хөгжлийн шинэ загвар руу шилжихдээ бусад улс орны нөөц бололцоог Хятадын нөөц бололцоотой уялдуулах хэрэгтэй гэж үзэж байгаа. Хөгжлийн шинэ загвараа хятадын удирдлагууд танилцуулсан. Ингэхдээ инноваци, технологийн хөгжил, хөдөлмөрийн бүтээмж дээр суурилсан нээлттэй, ногоон хөгжлийг дэмжсэн хөгжлийн моделийг сонгож байна гэсэн. Монгол Улсын хувьд ОХУ-Монгол Хятад гэсэн гурван эдийн засгийн коридоор байгуулах тухайд асуудлыг ярьсан. Бид дэд бүтцээр гадна худалдаа эдийн засаг зэрэг

өргөн хүрэн санал солилцлоо” гэсэн юм. Өмнөд хөршөөс орж ирэх буцалтгүй тусламжийн тухайд юунд зарцуулахаа хараахан шийдээгүй байгаа аж. Харин өхний ээлжинд авах 350 сая юанийг гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулахаар болжээ. Гадаад харилцааны сайд өмнөд хөршид хийгдсэн айлчлалын үеэр ОУВС-ийн захиралтай уулзсан бөгөөд Монгол Улсыг “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамруулах ажил өнөөдөр шийдэгдэнэ гэсэн хүлээлт байгаагаа дуулгалаа. Сүүлийн үед хийгдэх томоохон айлчлалаас онцвол, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ирэх сард Казахстаны Астана хотод болох ШХАБ-ын удирдагч нарын уулзалтад оролцох аж. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Санкт-Петербургийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцохоор болжээ.

3.Энхболдын хөрөг Төрийн ордонд заларлаа

Хууль тогтоох дээд байгууллага УИХ-ыг удирдаж байсан үе үеийн дарга нарын хөрөг зургийг Төрийн ордонд байрлуулдаг уламжлалын дагуу өчигдөр 2012-2016 онд УИХ-ын даргаар ажилласан 3.Энхболдын хөрөг зургийг байрлуулав. Ёслолд УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын дарга асан 3.Энхболд, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, Я.Санжмятав, Б.Пүрэвдорж, Д.Мурат, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, хөргийг бүтээсэн зураач Т.Чингис нар оролцлоо. Энэ үеэр УИХ-ын дарга М.Энхболд хэлсэн үгэндээ “1914-1919 онд Сайн ноён хан Т.Намансүрэн Монгол Улсын Дээд хурлын даргаар ажилласан тэр цагаас Монгол Улсад байнгын ажиллагаатай



парламент үүссэн гэж үздэг. Үүнээс хойшхи УИХ-ын 10 дахь даргаар томилгодон ажилласан хүн нь 3.Энхболд та юм. Өнөөдөр таны төрсөн өдөр тохиож байгаа юм байна. Танд УИХ-ын нэрийн өмнөөс төрсөн өдрийн мэнд хүргэж, сайн сайхныг хүсье. Монгол Улсаа хөгжүүлэх үйл хэрэгт

эв саналаа нэгтгэх, хамтран ажиллах чухал цаг үе тохиож байна. Таныг хариуцлагатай, шударга төрийг цогцлоон бэхжүүлэх үйлсэд цашид ч хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна” гэлээ Дараа нь УИХ-ын дарга М.Энхболд УИХ-ын 10 дахь дарга 3.Энхболдод дурсгалын зүйл гардуулав

Иг шигийн аргаар гараагийн Ерөнхийлөгчийг тодруулчихаж

Ирээдүйн 100 жилд дэлхийд тохиох үйл явдлыг зөгнөн бичиж, 9 эрдэнээр бүтээсэн “Дэлхийн нууц товчоо” хосгүй үнэт номын нээлт, гууцлага хуралдаа 5 сарын 26-нд “Чингис” зочид буудалд болно. Энэ номонд Монгол улсын 5 факш шинэ Ерөнхийлөгчийн тухай бичсэн ба номоо өргөн барих юм.

ЭНЭ НОМЫН ЭЗЭН ХЭН БЭ?

Тасалбар: 120.600 / Тасалбар 210.600 бага гэрэлгүй /
Facebook.com/Mongolian100 | Өмнө 5985-8084, 8825-8084 утсаар

Энэ сарын 26-нд нэгэн сонирхолтой ном нээлтээ хийх аж. Тодруулбал, ирээдүйн 100 жилд дэлхийд тохиох үйл явдлыг зөгнөн бичиж, есөн эрдэнээр бүтээсэн “Дэлхийн нууц товчоо” гэх хосгүй үнэт номын дуудлага худалдаа болох гэнэ. Тасалбарын үнэ нь гэхэд л 126.600 төгрөг бөгөөд үнэ дотор нь 210.600 төгрөгийн бэлэг дагалдана хэмээн зохион байгуулагчид онцлолоо. Хамгийн сонирхолтой нь энэхүү номонд Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн тухай өгүүлсэн аж. Бид номын дуудлага худалдааг зохион байгуулж буй хүмүүстэй холбогдож энэ талаар тодруулахад “Нээлтээ хийх нь үнэн. Тав дахь Ерөнхийлөгч тодорсны дараа бид номоо албан ёсоор гардуулж өгнө” хэмээлээ. Уг номонд Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн тухай зөгнөхдөө “Мондгор хамартай, нүд бүрэлзээтэй. Малгай зохин тааруулж өмсөөгүй. Яриа явдал хоёр нь ялгамжтай ч ямба нэгддэггүй сонжоо харагч. Ядаж түдхэггүй зарлар сууна” хэмээжээ. Энэхүү ном чухам яагаад Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн нээлтээ хийж буй нь тун сонирхолтой. Ер нь сүүлийн үед сонгуулийн болгоны өмнө зөн билэгч ирдэг, эс бөгөөс ниймэрхүү утга агуулгатай мэдээлэл түгдэг болсон нь төрийн сэнтийд залрахыг хүсэгчид маань шашин төрийг хослуулахыг хүсээд байна уу хэмээн хардаг хүргэж байна. 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болоход ОХУ-ын шилдэг зөн билэгчдийн нэг нь Монголд айлчилж, дараагийн Ерөнхийлөгч шил зүүдэг намхан, боловсрол өндөртэй хүн байна хэмээн мэдэгдэж байсан удаатай. Тэгвэл яг одоо Монголд мөн л ОХУ-ын шилдэг зөн билэгч Дмитрий Волхов ирсэн, ид шидийн гэмээр ийм ном нээлтээ хийж буй нь өнөөч л зөн билгийн арга ухаанаар иргэдийн тархи угаах гэсэн ядмаг арга уу хэмээн жиг жуг хийж эхэллээ.

Хуульч эрдэмтэд салбарынхаа бодлогыг хэлэлцэв

Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар Хуульч эрдэмтдийн үндэсний анхдугаар чуулган өчигдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон болон Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын удирдлагууд, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл оролцов. Хуульч эрдэмтдийн анхдугаар чуулганыг нээж ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт хэлсэн үгэндээ “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хууль зүйн болон шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх чиглэлээр тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх асуудлыг авч хэлэлцэх нь энэхүү чуулганы нэг үндсэн зорилго юм. Засгийн газрын үйл ажилгааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлснээр Монгол оронд эрх зүйт төрийг бүрнээ төлөвшүүлэн хөгжүүлэх, хүний эрхийг хангах баталгааг улам бүр сайжруулах, эрх зүйн шинэчлэлийг дэлхийн нийтийн эрх зүйн тогтолцооны болон өөрийн орны хөгжлийн үндсэн чиг хандлагын дагуу гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх үйл явцыг хангахад шийдвэрлэх хүчин зүйл байх болно” гэж онцлон тэмдэглэв. Чуулганд Академич С.Нарангэрэл “Хуульч эрдэмтдийн үүрэг хариуцлага”, Академич Ж.Амарсанаа “Монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн тольдохуй” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Манай оронд 1960-аад оноос хойш өнөөдрийг хүртэл нийтдээ хууль зүйн шинжлэх ухааны 185 эрдэмтэн төрсөн байдаг. Өнөөдрийн энэхүү хуульч эрдэмтдийн анхдугаар чуулганд 160 гаруй эрдэмтэд хурал цугласан бөгөөд тэдний хамгийн ахмад нь 88 настай хамгийн залуу нь 29 настай эрдэмтэн байлаа. Сүүлийн жилүүдэд Монголын хууль зүйн салбар хууль зүйн шинжлэх ухааны хөгжил өндөртэй Герман, Орос, Америк, Япон, Хятад, Унгар зэрэг олон оронд төрсөн монгол эрдэмтдээр өгнээгээ тасралтгүй тэлж байна. Түүгээр ч зогсохгүй Монголд эрдмийн зэрэг хамгаалсан гадаадын цөөнгүй иргэн байдаг аж. Хууль зүйн салбарынхан асуудлаа ярилцаж, гарц шийдэл хайсан, мэргэжил нэгтгүүдтэйгээ уулзаж, мэргэн санаагаа уралдуулсан үр дүнтэй арга хэмжээ болсныг хүрэлцсэн ирсэн зочид төлөөлөгчид хэлж байв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дулмаагийн ӨРХИЙН ОРЛОГО өссөн шалтгаан юу байв

Дугаарын **60** мөр

Зургадугаар сарын 1-нийг “Автомашингүй өдөр” болгоё

Төгсгөл.

Түрүүч нь I нүүрт

Б.ӨНӨРТОГТОХ

“Дэлхийн улс орнуудын нийгэм эдийн засгийн байдлыг харьцуулсан жагсаалтад манай улс одоогоор 130-д жагсдаг. Өндөр хөгжилтэй, төсвийн орлого нь хэдэн тэрбум ам.доллараар хэмжигддэг, том том үйлдвэрүүд хөгжсөн орнуудтай дүйцүүлэх аргагүй ч хөгжингүй орнуудын жагсаалтад манайг харьцангуй урдуур яваа” хэмээн Төв банкны мэрэгжилтэн залуу онцолж билээ. 2006 он хүртэл бага орлоготой буюу ядуу орны жагсаалтад багтаж байсан Монгол Улс 2006 оноос хойш дундаж орлоготой буюу хөгжингүй орнуудын жагсаалтад орж ирсэн аж. Энэ жагсаалт дотроо дээд төвшинд явж байсан бид сүүлийн жилүүдэд доод төвшинд шилжиж орхисныг мөн л тоон баримтаар харуулав. Өөрөөр хэлбэл, “дундаж орлогын хавх” гэгч зүйлээс бид гарч чадахгүй явсаар дуусах вий хэмээн санаа зовдог учраас энэ хавхаас гарахын тулд төр засаг, Төв банк, Сангийн яам бүх талаар чармайж байгааг ч дуулгасан юм. Харамсалтай нь одоогоор энэ хавхнаас гарах боломж бидэнд алга. 2011 онд түүхий эдийн үнэ

сая ам.доллар гадагшаа өгөх боловч дотооддоо энэ мөнгийг олох нэг ч том төсөл хөдлөөгүй байгааг худлаа гэж хэлэхгүй биз.

Статистикийн байгууллага сонгуулийн захиалгаар ажиллав уу

Энэ мэтээр эдийн засгийн бодит тоог харахаар энэ улсад болжбүтэжбайгаа зүйл огт алга. Гэтэл Гүйцэтгэх засаглалын тэргүүнээсээ эхлээд ч эдийн засаг сэргэлээ хэмээн шуудах аж. Үндэсний статистикийн байгууллага нь өрхийн орлого өссөн, гадаад худалдаа, аж үйлдвэрийн салбар, нийгмийн даатгал, халамж, ДНБ, үнэ, мөнгөний нийлүүлэлт цөм өссөн гэсэн дүн мэдээг хэдхэн хоногийн өмнө танилцуулав. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ энэ оны дөрөвдүгээр сарын эцсээр 12.4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 18 хувиар өссөн дүн мэдээг танилцуулав. Өрхийн орлого мөн л өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн нь тэтгэвэр, цалин хөлсний хэмжээ, хөдөө аж ахуйн орлого өссөнтэй холбоотой гэсэн тоон мэдээ өгчээ. Арай ч чанаргүй зээлийн хэмжээ буурлаа хэмээн хийрхсэнгүй өнгөрлөө. Банкны салбарынхан болон эдийн засагчдын ярьж хэлж байгаатай алд дэлэм зөрүүтэй мэдээллийг тэд өгч суна. Өрхийн орлого өссөн үндсэн шалтгааны дийлэнхийг тэтгэвэр, цалин өссөн учраас хэмээн тайлбарлажээ. Гэвч хэзээ цалин нэмсэн билээ хэмээн Статистикийн байгууллагаас асууя. Тэтгэврийг 20-50 мянган төгрөгөөр нэмсэнээс өөрөөр огтхон ч өөрчлөлт орсонгүй. Эсрэгээрээ долоон төрлийн татвар нэмэгдэж, шатахууны үнэ литр тутамдаа 100 төгрөгөөр нэмэгдсэн. Чалькод төлөх өөрөө дуусгасан ч Монгол руу чиглэсэн хөрөнгө оруулалт сэжигрсэнгүй. Уул уурхайн хөрөнгө оруулалтад ахиц гарсангүй, өнөөх л бахь байдагараа үлстөржиж суугаа. Дэлхийн зах зээлд тонн нүүрсний үнэ 300 ам.доллар хүрч галзуурч байхад, манай улс дөнгөж 50 ам.доллараар гаргаж байгааг худлаа гэж хэлэхгүй. Төсвийн орлого нь 235 тэрбум төгрөгөөр тасарчихаад байгаа улсад яаж ч гэдсэн эдийн засгийн орлого өсч, гадаад худалдаа

гайхалтай сэргэх боломж харагдахгүй байгаа юм.

Тиймээс Үндэсний статистикийн байгууллага үлстөржсөн мэдэгдэл гаргав уу хэмээн хардахад хүрч байна. Монголын хэт баян, хамгийн ядуухоёрын цалинг харьцуулаад дундаж гаргачихдаг учраас харьцангуй дүн гарах нь ч аргагүй болов уу.

Тун удахгүй Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болно. Тиймдээ ч улсаараа дампуурчихаж гэсэн сөрөг мессеж явуулахгүйн тулд сонгууль угтсан, захиалгын мэдэгдэл хийлээ хэмээн үлстөрчид, эдийн засагчид онцолж байгааг энд сануулахгүй өнгөрч болохгүй юм. Төсвийн алдагдалаа ч нөхөж чадахгүй байгаа улсад өрхийн хүн амын тоо хасагдчихаагүй л бол өрхийн орлого нэмэгдэх боломж байхгүй. Дорж, Дулмаа хоёр таван хүүхдийнхээ гурвыг нь хөөгөөд явуулчихвал магад өрхийн орлого өсч мэдэх. Түүнээс өөрөөр өрхийн орлого өсөх шалтгааныг эрээд олсонгүй. Эдийн засаг тоон баримтыг өөрчлөөд бичихээр, эсвэл хэн нэг дарга гадагшаа айлчлаад ирэхээр л сайжирдаггүй гэдгийг бид олон жилийн туршлагаас мэднэ. Тэтгэврийн зээлийн хүүг, бууруулж цалин тэтгэврийн хүүг тэглэхээр ч сайжрахгүй. Гагцхүү уул уурхайгаас хэт хамааралтай болчихсон эдийн засгаа солонгоруулах, том төслөө хөдөлгөж гэмээнэ энэ улсад өөрчлөлт хийгдэх учиртай юм. Хамгийн гол нь мөнгө орж ирэх, баялгаа мөнгө болгох гарц болгоноо ашиглах ёстой.

Монголд мөнгө орж ирэх нь, гэхдээ...

Эдийн засаг харин ч “дефолт”-оос гарч дефляци боллоо гэсэн хэтэрхий онолдсон, ойлгомжгүй эдийн засгийн энд яриад ч хэрэггүй. Дулмаагийн авдаг цалин нэмэгдэж, таван хүүхэд нь хоногийн хоолондоо санаа зовохгүй унтаж л байвал жинхэнэ эдийн засгийн сэргэлт болно. Том тоо өөрчлөгдөж, онолын талаасаа сайжрах нь эдийн засагч, үлстөрчид, Засгийн газарт хэрэгтэй байж болох ч бидний амьдралд цалин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа хямд байх л чухал. Махаа хямд үнээр худалдаа авчихдаг,

...5.5 тэрбум ам.долларын зээлийн шугам нээгдэж Энэтхэг, Хятад, БНСУ, Япон зэрэг улсаас гадна Валютын сангаас 1.5 тэрбум ам.долларын зээл авна. Хэдийгээр дийлэнх нь төсвийн алдагдал нөхөх, валютын сангийн нөөцөө бүрдүүлэхэд ашиглах ч боловсруулах үйлдвэр барих зэрэг томоохон ажил урагшилж чадвал жинхэнэ утгаараа “сайхан мэдээ” болох нь. Тавдугаар сарын сүүлч, зургадугаар сарын эхээр Монголд мөнгө орж ирнэ. Харин тэр мөнгийг халамж хэлбэрээр тарааж, санал авах зорилгоор битгий ашиглаасай хэмээн хүсье дээ...

өссөн, Оюутолгойн ил уурхайн бүтээн байгуулалт эхэлсэн үед манайх дэлхийн зах зээлд дээгүүр жаалж явсан цаг үе бий. Гэвч энэ сайхан үе эргээд ирэхгүй нь тодорхой болсон. Монгол Улсын эдийн засгийн тоон мэдээ дандаа сөрөг талдаа явж байгааг олон улсын агентлагууд онцолж буй юм.

Манай улсын эдийн засгийн бодит тооцооллыг гаргадаг Moody's, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд эдийн засгийн нөхцөл байдлыг “тогтвортой” хэмээн онцолсон ч үүнээс бууруулж болохгүйг хатуу анхааруулсан гэх. 2016 онд бид тавхан тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг гадны зах зээлд гаргажээ. Тэрний дийлэнх нь зэс, нүүрс. Монгол Улсын эдийн засгийн 90 орчим хувь нь уул уурхайгаас хамааралтай, сүүлийн зургаан жилийн төсөв нь дандаа алдагдалтай, валютын ханш тогтворгүй хэлбэлзэж буй, банкны салбарын чанаргүй зээл нийт зээлийн 8.3 хувийг эзэлсэн. Жилдээ 20-30 хувиар нэмэгдэж байгаа гэх мэтээр эдийн засагт дандаа таагүй мэдээ дуулдаж байх юм. Ганц гялтайх мэдээ нь БНХАУ-ын Ардын банктай хийсэн Төв банкны своп хэлцэл үргэлжлэхээр болж ам.долларын ханшаа 3000 давуулж алдах айдсаас ангижирлаа. Гэсэн ч ханшийг өнөөдөр байгаагаас /ам.долларын ханш өчигдрийн байдлаар 2417 төгрөгтэй тэнцэж байна/ доошлуулах, Төв банкны валютын сангийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлага өнөө хэр шийдэл олоогүй байна. Ядахад, АН-ын эрх баригчдын зам барихад зарцуулсан гэх Чингис бондын хүү гэж жилдээ 500



өмнө болсон уг шүүх хурлаар түүнийг БТА банканд учруулсан 2.1 тэрбум ам.долларын хохирлыг төлүүлэх шийдвэр гарч байв. 2.1 тэрбум ам.долларын хохирол бол түүний учруулсан хохиролын нэгээхэн хэсэг нь юм. Өдгөө ч Лондонгийн шүүхээс түүний хэргийг мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байгаа ажээ. Английн бүх шатны шүүхүүд түүний учруулсан хохиролыг 4.3 тэрбум

гэж үзэж байгаа ажээ. М.Аблязов оросын АМТ банкаар дамжуулан гаргасан мөнгө нь хэдэн тэрбумаар хэмжигдэж байгаа юм. АМТ банк нь БТА болон оросын бусад банкнаас хүүгийгээр зээл авдаг банкны нэг байв. АМТ банкнаас америкийн Morgan Chase банкуу мөнгө гуйвуулж American Express-ээр дамжуулж гаргадаг байжээ. Түүнээс гадна М.Аблязов энэ мөнгөөрөө хуурамч компанийн нэр дээр ОХУ, Украин болон европын улс орнуудад янз бүрийн актив худалдан авдаг байжээ. Саяхан Казахстанд болсон шүүх хурлаар тус улсад учруулсан хохирол нь 7.5 тэрбум ам.доллар гэж тогтоожээ. М.Аблязов олон улсын санхүүгийн байгууллагууд, иргэдийн хадгаламжийг их хэмжээгээр татаж авч гадаадын компанируу зээл хэлбэрээр гаргадаг байжээ.

12 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ЛУЙВАРЧИН

Сүүлийн үед европын үлстөрчдийг шүүхийн шийдвэрт нөлөөлөх оролдлого удаа дараа гаргаж байгаа талаар ихээхэн шүүмжлэх болсон. Тухайлбал, саяхан европарламентийн хэсэг гишүүд Казахстаны зартай гэмт хэргэгтэн Мухтар Аблязов болон түүний хамсаатнуудыг эрэн сурвалжлах мэдэгдлийг хүчингүй болгохоор Интерполд ханджээ. Европын хэд хэдэн улс орныг төлөөлж суугаа төлөөлөгчдийн гарын үсэгтэй уг хүсэлтийг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх хүмүүс байгаа юм. Учир нь М.Аблязовын санхүүжүүлдэг Польшид төвтэй “Нээлттэй ярилцлага” сангийн нөлөөлөөр дээрх хүсэлтийг гаргасан гэж таамаглаж байгаа ажээ. Уг сан нь ОХУ, Казахстан, Украин зэрэг улс орнуудын ардчиллын байдлыг “судалдаг” юм. Гэтэл дээрх улс орнуудад М.Аблязов хамгийн их хохирол учруулсан байдаг. “Нээлттэй ярилцлага” сангийнхан европарламентийнхэнд Мухтар Аблязовыг улс төрийн орогнол хүсэгч, сөрөг хүчний дуу хоолой мэтээр ойлгуулжээ. Англи, ОХУ, Казахстан, Украины шүүхээс түүнийг санхүүгийн луйвар хийснийг нь тогтоосон байдаг. 2012 онд Лондонд болсон шүүх хурлаар Мухтар Аблязовыг Казахстаны БТА банкаас их хэмжээний мөнгө луйвардсан, түүнийгээ Их Британийн эзэмшил Виржинийн аралд бүртгэлтэй хэд хэдэн хуурамч компанийн нэрлүү шилжүүлж хувьдаа завшсан гэж үзжээ. Таван жилийн

ам.доллар гэж тогтоожээ. Энэ их хэмжээний мөнгийг Казахстаны БТА банкнаас 10 гаруй улс орны 1300 орчим оффшор компаниар дамжуулан гаргасан байдаг. Англичууд 2012 онд Мухтар Аблязовыг олон улсын гэмт хэргэгтэн гэж үзэж түүний дүрвэгч, улс төрийн орогнол хүсэгч гэдэг статусыг нь хасаж байжээ. Францын тал ч түүнийг санхүүгийн луйвар хийсэн гэдгийг нь хүлээн зөвшөөрч ОХУ-ын талд хүлээлгэж өгөх шийдвэрийг 2015 оны есдүгээр сард гаргаж байв. Гэвч түүний хамсаатнууд нь ямар нэгэн байдлаар дээрх шийдвэрт нөлөөлж ОХУ-д шилжүүлэн өгөхийг нь боллуулж чаджээ. Францын тал Мухтар Аблязов улс төрийн үзэл бодлоосоо болж мөрдлөг, мөшгөлтөнд орсон

БТА банкны удирдах зөвлөлийн тэргүүн дэд дарга Ж.Жаримбетов дээрх санхүүгийн луйврыг зохион байгуулахад оролцож байснаа хүлээн зөвшөөрч луйврын схемийг хэрхэн зурж, хийж байсныг нотложээ. Тэрээр мэдүүлэгтээ гадаад улс оронруу гаргасан мөнгөө Английн “Ист Бридж Кэпитал Лимитед” компаниар дамжуулан “угааж” байсныг батласан байна. Мөрдөн байцаалтын явцад Москвад офисстой, Лондонд байгуулагдсан дээр компани луйвраар орж гарсан мөнгийг “угааж” зарцуулдаг хөрөнгө оруулагчийн үүргийг гүйцэтгэдэг байв. Мухтар Аблязовын луйвардсан бүх мөнгөний хэмжээ 12 тэрбум ам.доллар болсон ажээ. Энэ бол Казахстаны иргэдийн тэтгэвэр тэтгэмж, хадгаламж, ОХУ, Украин, Казахстаны төрийн байгууллагуудын зээлийн сангийн хөрөнгө байжээ. Европын зүгээс хөгжиж буй улс орнуудыг итгэл муутайхнаар хадаг хэвээр байгаа. Өөрөөр хэлбэл ардчиллын үндсэн зарчим, хүний эрхийн асуудал бүрдэх болоогүй гэж үздэг. Энэ байдлыг зарим нэг луйварчид ашиглан өөрсдийгөө хүний эрхийн төлөө тэмцэгч, ардчилсан үзэлтэн мэтээр тунхаглаж европын улс орнуудад толгой хорогддог байдал ажиглагддаг юм. Нэг үгээр хэлбэл гэмт хэргэгтэн, ардчилсан үзэлтэн хоёрын ялгааг хэрхэн харахаас хамаарч тухайн гэмт хэргэгтэнд хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудал яригдах юм.

Н.ОЮУН

ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



Т.АРИУНБААТАР:

ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАМГИЙН АШИГТАЙ ХУВИЛБАРААР АЖИЛЛУУЛНА

Төгсгөл.
Түүрч нь I нүүрт

“Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг, “Монголын төмөр зам” ТӨХК хоёр өөр байгууллага. Ачааны төрлөөс үл хамаарч цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хамтарч нэг зүтгүүрээр ачаагаа тээвэрлэх боломжтой юу. Тийм зохицуулалт танайх хийж болох уу?

Энэ бол байгууллагын дотоод асуудал. Өөрөөр хэлбэл, тус тусдаа нэг зүтгүүрээр явуулах, жинг нь гүйцээгээд нэг зүтгүүрээр хамтраад явуулах эсэх нь тухайн байгууллагын өөрийн эрх ашиг буюу хоорондын асуудал. Бид бол хөдөлгөөнийг л зохицуулна. Төвийн үндсэн эрх зүй нь улсын болон нийгмийн чанартай ачаанууд, олон улсын зорчигч тээвэр, дотоодын зорчигч тээвэр, транзит болон нүүрсний тээвэр, мөн нэг төмөр замаас нөгөө төмөр замд хүлээлгэн өгдөг ачаануудыг тээвэрлэхэд л оролцох ёстой. Хүмүүсийн дунд түгээмэл буруу ойлголт байдаг. Галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулна гэхээр төмөр замын байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд нь оролцож, замын цагдаа шиг зохицуулж, удирдана гэж ойлгодог. Гэтэл бид төмөр замын байгууллагуудын хоорондын тэгш эрх, тээврийн чиглэлийн үйлчилгээний шударга өрсөлдөөнийг бий болгох л зорилготой юм.

Хөдөлгөөний ачааллыг нь тэнцвэржүүлэх гэж ойлгож болох уу?

Тийм ээ. Ачааллыг нь тэнцвэржүүлэх буюу адил тэгш байлгана гэж ойлгож болно.

Яг одоо ийм ажиллагаагаа явуулж эхэлсэн үү?

Ерөнхийдөө таван жилийн хугацаанд Европын төмөр замын стандартуудыг Монгол Улсын хөрсөн дээр буулгах бэлтгэл ажлуудыг хийж байна. Хэдийгээр бид галт тэрэгний хөдөлгөөнд иж бүрнээр нь хяналт тавихгүй байгаа боловч галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж өгч, биелэлтийг нь авч байна. Зурмаг гэдэг нь улсын болон нийгмийн чанартай ачаанууд, олон улсын зорчигч тээвэр, дотоодын зорчигч тээвэр, транзит тээвэр, нүүрсний тээвэр зэрэг бүхий л галт тэрэгний явах графикийг нарийн гаргана гэсэн үг. Транзит тээвэр буюу дамжин өнгөрөх тээвэр гэдгийг хүмүүс одоо мэддэг болсон. Монгол Улсын хилийг нэвтрэн Монголын нутаг дэвсгэрээр дамжин гуравдугч оронд хийгдэх тээвэрлэлтийг л транзит тээвэр гэж байгаа юм. Энэ тээврийг аль болох богино хугацаанд дамжин өнгөрүүлэх нь эдийн засгийн өндөр үр ашгтай. Транзит ачаа нэмэгдээд ирэхээр манай төмөр замын тээх, нэвтрүүлэх чадвар нэмэгдэх

шаардлагатай болно. Өдөрт 24 галт тэрэг явуулах ёстой. Үүний нэг хэсэг нь зорчигчийн галт тэрэгт оногдоно, зарим нь дотоод тээвэртээ оногдоно. Ингэхээр транзит галт тэрэгний зурмагийг яаж гаргах вэ, хугацааг яаж бууруулах вэ гэдэг зохицуулалтыг хийж байна. Ерөнхийдөө ийм зохицуулалтыг хийгээд явахад ЦУП (Центр управления перевозками) буюу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийг зайлшгүй байгуулах ёстой. Нэгдсэн төв маань иж бүрнээрээ ашиглалтад орчихвол Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх төмөр замаар хэний галт тэрэг, хаана явж байгааг дэлгэцээр хянаж, зохицуулаад явчихна.

“Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК гэсэн төмөр замын байгууллагуудтай танай төв яг одоо ямар байдлаар хамтарч ажиллаж байна?

Яг одоогийн байдлаар зөвхөн зурмаг дээр л хамтран ажиллаж байна. Мөн Зам тээврийн хөгжлийн яамыг төмөр замын статистик мэдээллээр тогтмол хангаж байгаа. Статистик мэдээллийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төмөр замын байгууллагуудын зорчигч болон ачаа тээвэрлэлт, ачаа эргэлт, транзит ачааны талаархи мэдээллийг авч нэгтгэн, салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн хөтөлж, олон нийтэд ил тод мэдээлж ажилладаг.

Танай төвийн баталсан нэгдсэн зурмагаар энэ гурван байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа гэж ойлгож болох уу?

Тэгж ойлгож болно.
Хувь, хувьсгалын энэ гурван байгууллагаатай үл ойлголцох, үл итгэх тохиолдол гардаг уу?

Үүнийг ярихаас өмнө нэг зүйлийг хэлэх нь зүйтэй. Манай улсын хэмжээнд төмөр замын ийм чиглэлийн байгууллага өмнө нь байгаагүй тул төмөр замын салбарын бүхий л асуудалд “УБТЗ” ХНН улсаа төлөөлөн оролцдог байсан. Энэ ч утгаараа Төмөр замын хэрэг ажлыг “УБТЗ”-ын дарга хавсран гүйцэтгэдэг байсан. Ингээд тэдний хийж ирсэн ажилд хөндлөнгөөс оролцоод ирэхээр үл ойлголцох асуудал гардаг байсан. Одоо бол Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УИГ маань хувь нийлүүлсэн нийгэмлэг, хувийн болон улсын төмөр замын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг мөрдөөгүйгээс осол аварга, хохирол гарсан тохиолдол байдаг уу?

Төмөр замын аливаа ослоод зурмаг мөрдөөгүй гэхээсээ илүү хувь хүний хариуцлагагүй

байдлаас болж их гардаг. Зурмагийг хэдийгээр хүн өөрөө хийж байгаа боловч цаана нь автоматаар тохируулж өгч байдаг.

Хойноос урагш чиглэсэн манай гол төмөр замыг газрын зураг дээрээс харахад шулуун зам боловч нарийн тооцоход маш их тахиралдсан байдаг юм билээ. Энэ нь эдийн засаг, цаг хугацааны хувьд маш их алдагдалтай байдаг болов уу гэж боддог?

Тийм шүү. Хоолтын даваа гэхэд маш өгсүүр, уруу зам ихтэй. Төмөр зам тахир эргэх бүрт мянганы нарийвчлалаар өргөгдөж байж давааны орой дээр гараад буудаг. Мэдээж орой руу гарахын тулд галт тэрэг маш бага хурдтайгаар гардаг. Тиймээс төмөр замын нэвтрэн өнгөрүүлэх болон даацын чадвар тэнд маш их алдагддаг. Улаанбаатарт орж ирж байгаа төмөр зам Рашаантаас наашаа Эмээлтийн давааг өгссөөр байгаад орж ирдэг. Энэ хоёрын хооронд хэрвээ шулуун явдаг

...Хоолтын даваа гэхэд маш өгсүүр, уруу зам ихтэй. Төмөр зам тахир эргэх бүрт мянганы нарийвчлалаар өргөгдөж байж давааны орой дээр гараад буудаг. Мэдээж орой руу гарахын тулд галт тэрэг маш бага хурдтайгаар гардаг. Тиймээс төмөр замын нэвтрэн өнгөрүүлэх болон даацын чадвар тэнд маш их алдагддаг. Улаанбаатарт орж ирж байгаа төмөр зам Рашаантаас наашаа Эмээлтийн давааг өгссөөр байгаад орж ирдэг. Энэ хоёрын хооронд хэрвээ шулуун явдаг бол дараагийнхаа өртөөнд хүрч нөгөө галт тэрэг нь зөрөөд хурдан эргэж болдог...

бол дараагийнхаа өртөөнд хүрч нөгөө галт тэрэг нь зөрөөд хурдан эргэж болдог. Гэтэл энд нэг талдаа 45 минут зарцуулдаг. Өөрөөр хэлбэл, 45 минутыг 24 цагтаа хуваагаад үзэхэд тэнд арван хэдхэн хос галт тэрэг л хоёр талдаа гарах боломжтой болж байгаа юм. Үүнийг замын хүнд аясууд гэж яриад байгаа хэрэг. Харин орчин үед тунель буюу хонгил ашигладаг болсон.

“Монгол Улсад барьж байгаа, цаашид барих төмөр замуудын зурагтай танилцаж байсан уу. Энэ байдлыг засч залруулсан байдаг болов уу?”

Төмөр замын дэлхийн хөгжил нэг хэмнэлтэй болсон. Нам дор газар байвал тэгшлээд өндөрлөх, өндөр газар байвал сэтгэлж замаа тавьж байна. Нэг төвшний төмөр зам гэдэг нь бидний ярьдгаар хурдны галт тэрэгний замыг хэлээд байгаа юм. Хурдны галт тэрэг нь нам дор байсан ч, өндөрлөг байсан ч нэгэн хэмээр хурдалдаг. Эрдэнэтийн “Аспайр майнинг” компанийн барих гэж байгаа төмөр замыг аль болох

нэг төвшинд барих тал дээр анхаарч ажиллаж байгаа юм билээ. Хамгийн сайн жишээ бол Тавантолгойн төмөр зам. Төмөр замыг нэг төвшинд барих нь өөрөө эдийн засгийн маш их үр өгөөжтэй.

Тэгэхээр Ухаахудаг, Гашуунсухайтын төмөр замын суурь бүтэц буюу шороон даланг нэг төвшинд, стандартад нийцүүлж барьж байгаа гэж ойлгож болох нь ээ?

Тийм ээ. Говийн бүс нутаг учраас даваа нугачаа таараагүй, харьцангуй нэг төвшинд ойртуулж барьж байгаа гэж хэлж болно. Гэхдээ бүх юм нь 100 хувь нэг төвшинд баригдсан төмөр зам бол өндөр хурдны зам л байдаг.

Танайх Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан байгууллага. Төмөр замтай гадны улс орнуудад ч танайхтай адил төрлийн байгууллагууд бий. Энэ төв байгууллагдах үндсэн шалтгаан нь юу вэ?

Мэргэжилтэн гэдэг бол хамгийн үнэт капитал. Тэгэхээр энэ капиталыг бий болгохын тулд бид одоо байгаа мэргэжилтнүүдээ чадваржуулах ажлыг зохион байгуулдаг. Мөн чадвартай боловсон хүчин ажилд авахыг эрмэлздэг. Гэвч харамсалтай нь төрийн байгууллагын цалин ямар байгаа билээ. Чадвартай хүн олж ажиллуулахад хүндрэл гардгийг нуугаад яах вэ. Бид өнөөдөр олон улсын төвшинд нийцсэн, мэргэжлийн байгууллага болохын тулд гадаад дотоодын олон байгууллагаатай харилцаатай ажиллаж байна. ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны их сургуультай таван жилийн гэрээ байгуулан ажиллаж байна. БНХАУ-ын Галт тэрэгний дохиолол холбооны Шанхай хот дахь инженерийн салбараас зохион байгуулдаг Азийн улс орнуудын төмөр замын байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад жил бүр хоёр хүн, мөн БНХАУ-ын Худалдааны яам, Олон улсын худалдаа, бизнесийн академис хөгжиж буй орнуудад зориулан зохион байгуулдаг урт болон богино хугацааны сургалтад төмөр замын салбарын мэргэжилтнүүдийг жил бүр хамруулдаг. Өнөөдөр манай төвд мэргэжил дээшлүүлэгүй, өөрийгөө боловсруулж чадавхижуулаагүй мэргэжилтэн байхгүй гэж хэлж болно. Энэ жилийн сургалтын хөтөлбөр маань эхэлчихсэн. Манай төвөөс хоёр мэргэжилтэн сургалтад явчихсан. Дараагийн ээлжийн мэргэжилтэн ирэх сарын 03-нд явахаар бэлтгэлээ хангаж байна. Нэмж хэлэхэд, төвийн батлагдсан төсөвт боловсон хүчнийг чадавхжуулах, сургах, мэргэжил дээшлүүлэх зардал тусгагддаггүй. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас төрийн болон төсөвт байгууллагуудыг төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлсэн байгаа. Өнөөгийн нөхцөлд манайх дотоод бололцоогоо дайчлан ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг болон төмөр замын салбарын чиглэлээр богино болон дунд хугацааны сургалт зохион байгуулдаг гадаад орны болон олон улсын байгууллагаатай холбоо тогтоож, хүлээн авагч талын буюу уригч талын зардлаар салбарын болон төвийн ажилтнуудаа сургалтад хамруулж байгаа нь багагүй амжилт гэж бодож байна. Мөн дотооддоо Тээврийн дээд сургуультай хамтран төвийн ажилтнуудынхаа мэдлэг, үр чадварыг дээшлүүлж, мэргэжлүүлэх сургалтад хамруулдаг.

Одоогоор хэчнээн мэргэжилтэн сургаад байна вэ?

2015 оноос хойш БНХАУ-ын Шанхай болон Ченду хотод 18, ОХУ-ын Эрхүү хотод 15, Тээврийн дээд сургуульд 16

жинхэнэ утгаар нь явуулж эхэллээ гэж бодоход гадаад улс орны адил төстэй байгууллагуудтай ижил болон ялгаатай чанар нь юу байх бол?

Нэгдсэн төв гэдэг маань тухайн улсын аюулгүй байдалтай холбоотой, дэлхий нийтэд нэг л стандартад байдаг, төмөр замын тусгай стратегийн объект буюу нууцны зэрэглэлтэй, тухайн улсынхаа төр засгийн харьяа хяналтад байдаг байгууламж юм. Ямар нэгэн том хэмжээний осол аваар гарах, мөн улсын чанартай тусгай галт тэргүүд явах үед нэгдсэн төв нь галт тэрэгний хөдөлгөөний шууд удирдлагын үйл ажиллагаанд оролцдог.

Цаашид Монгол Улсад шинээр төмөр замын байгууллагууд нэмэгдэнэ. Иймд танай төвийн үйл ажиллагаа улам өргөжинө. Тэгэхээр мэдлэг чадвартай боловсон хүчний хэрэгцээ шаардлага гарна. Энэ тал дээр одоо ямар ажлууд

мэргэжилтнээ хамруулаад байна. Гэхдээ зөвхөн төвийнхөө бий ЗТХЯ, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ийн мэргэжилтнүүдийг ч хамруулдаг. Мөн зөвхөн төвийн ажилтнууд бус төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, инженер техникийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, холбогдох хууль тогтоомжийн нийцүүлэн хариуцлагын тогтоолоог бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж эхлээд байна.

ГТХЗНТ-ийн барилгын асуудал ямар шатандаа явж байна. Төвийн барилга баригдаад галт тэрэгний хөдөлгөөнийг хянаж эхлэхэд ажиллах боловсон хүчний тоо, бүтэц бүрэлдэхүүний хувьд яаж нэмэгдэх вэ?

Барилгын асуудал ярихаас өмнө тухайн газарт баригдах барилгын техник, эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслөө боловсруулах шаардлагаатай.

2013 онд Эдийн засгийн хөгжлийн сайдын тушаалаар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулахад шаардлагатай 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан байсан. Гэвч Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноор батлагдсан төсөв маань буцаагдсан. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилтээ ингээд ашиглаж чадаагүй юм. 2014-2016 онд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад удаа дараа хандсан боловч төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж шийдэгдээгүй байна. Ингээд бид 2015 онд М.Зоригтыг Зам, тээврийн сайдаар ажиллаж байх үед, Монгол Улсын эдийн засаг хүндрэлтэй байгаа энэ үед дотоод нөөц бололцоогоо ашиглан ТЭЗҮ, зураг төслөө боловсруулахаа гэгсэн санаачилга гаргасан. Үүний дагуу Эрхүү хотын Зам харилцааны сургуульд 15 мэргэжилтэн сургалтад хамруулж, мэргэжил дээшлүүлэн, ОХУ-ын Эрхүү хотын Дорнод-Сибирийн төмөр замын хөдөлгөөн удирдлагын төвийн үйл ажиллагаатай танилцсан. Мөн Хятад, Солонгос, Япон, Америк, Герман улсуудын адил төстэй үйл ажиллагаа явуулдаг төвүүдийн талаар судалсан. Ингээд бид ТЭЗҮ боловсруулах ажилдаа орж, 2016 оны зургадугаар сард ТЭЗҮ-ээ боловсруулж дуусгасан. Энэ үеэр төрийн захиргааны төв байгууллага болон төмөр замын байгууллагын дунд хоёр удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, санал зөвлөмжийг нь тусгаж чадсан. Барилгын хувьд газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласны хүчинд барилга баригдах газраа чөлөөлүүлж, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектороор ГТХЗНТ-ийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулснаар барилга барих ажил эхлээд бэлэн болчихоод байна.

Танай төв байгуулагдсанаар төмөр замын салбарт ямар өөрчлөлт шинэчлэлтүүд гарах бол?

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь бүрэн хүчин чадлаар ажилласнаар үр ашиг бүхий тээврийн оновчтой нэгдсэн систем бий болж, орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч, салбарын хөгжил шинэ төвшинд хүрнэ. Түүнчлэн төмөр замын тээврийн аюулгүй байдал хангагдаж, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож, олон улсад Монголын төмөр замын өрсөлдөх чадвар нэмэгдэх юм.

ДОРНОГОВИЙН МЭДЭЭ



Б.ЦЭНД-АЮУШ: ДОРНОГОВИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ ДУУССАН

VI нүүрт

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЧУХАЛ ГЭВ

VII нүүрт



Ч.ЧУЛУУН

Дорноговь аймгийн Засаг дарга Г.Энхтүвшинтэй хөгжлийн бодлого хийгээд их бүтээн байгуулалтын явц, нийгмийн тулгамдсан асуудлаа хэрхэн шийдвэрлэж буй талаар ярилцлаа.

-Дорноговь бол Монгол Улсын эдийн засагт нөлөөлж буй цөөн аймгийн нэг. Эдийн засгийн хувьд ч энэ цаг үед ажрахааргүй байгааг эдүгээ өрнүүлж буй их бүтээн байгуулах тухай ярьж болох ч хамгийн гол нь хөрөнгө оруулалт шүү дээ?

-Дорноговь аймаг хөгжлийнхөө ерөнхий төлөвлөгөөг тэргүүлэх гурван чиглэлээр тодорхойлсон. Нэгдүгээрт, уул уурхайд түшиглэсэн боловсруулах болон баяжуулах үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх явдал. Өөрөөр хэлбэл, Дорноговийн хөрсөн дор буй байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нэмүү өртөг шингээсэн боловсруулах болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж гэмээнэ иргэд маань ажилтай, орлоготой сайхан амьдарна. Хоёрдугаарт, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх. Манай аймаг хилийн хоёр боомттой. Монгол Улсын нийт ачаа эргэлтийн 60 гаруй хувийг импортлодог байнгын ажиллагаатай Замын-Үүдийн болон Хатанбулаг суман дахь Хангимандалын боомт байна. Цаад талд нь Өвөр Монголын өөртөө засах орны Бугат гээд олон сая хүнтэй, БНХАУ-ын төмөрлөгийн үйлдвэрлэл хөгжсөн том хот бий. Тиймээс бид энэ давуу байдлаа ашиглаад Дорноговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэхийн төлөө ажиллаж байна. Дорноговийг монголчууд төдийгүй дэлхийн улс орнуудад мэддэг. Хамрын хийд, Хан Баянзүрх уул, Шамбалын орон буюу жуулчдын сонирхлыг татдаг энергийн төвийг гадна дотны олон зуун жуулчин зорьж ирдэг. Тиймээс Өвөр монголчуудыг энергийн төвөөр аялуулах, дорноговьчуудыг Улаан-Үд, Эрхүү хотоор аялуулах ажлыг зохион байгуулж байгаа. Гуравдугаарт нь уламжлалт мал аж ахуйг нэрлэхээс аргагүй. Өмнөд хөрш Хятадын том зах зээлд малын гаралтай түүхийг эд болоод мах боловсруулан нийлүүлэх

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

Г.ЭНХТҮВШИН: ДОРНОГОВЬ МОНГОЛ УЛСЫН ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛНА

үйлдвэр байгуулах зорилт тавьсан. Дашрамд өгүүлэхэд, манайд тодруулбал хилийн бүсэд арьс шир боловсруулах томоохон үйлдвэр барихыг төр, засаг дэмжсэнийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

-Уул уурхай, аялал жуулчлалын салбарт түшиглэсэн хөгжлийн бодлого дагаад улсын чанартай томоохон бүтээн байгуулалт өрнөх нь ээ?

-Манай аймагт үйл ажиллагаагаа явуулдаг "Монполимент" компанийн "Монцемент"-ийн үйлдвэр жилд сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус үйлдвэрт Дорноговийн харьяа 300 гаруй хүн ажиллаж буй. Ирэх сарын 1-нээс манай үндэсний үйлдвэрлэгч МАК-ийн "Хөх зам"-ын цементийн үйлдвэр Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт удахгүй ашиглалтад орно. Өөрөөр хэлбэл, Монгол Улс энэ оноос жилд хэрэглэдэг 1.8 сая тонн цементээ манай аймагас татах боломж бүрдэж байгаа юм. Мөн Замын-Үүдэд хоёр томоохон бүтээн байгуулалтын ажил өрнөж эхэлсэн. Эхнийх нь Тээвэр ложистикийн төв бөгөөд Хятадаас нарийн царигтай төмөр замаар орж буй бараа бүтээгдэхүүнүүд шууд нарийн цариг дээрээ буух боломж бүрдэнэ. Нөгөө нь Замын-Үүдийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажил.

-Бүтээн байгуулалт, үйлдвэржилт дагаад Дорноговь аймгийн хүн ам өсөх нь ойлгомжтой. Ажлын байр, амьжиргааны түвшинг дагаад шилжилт хөдөлгөөн идэвхжиж таарна. Үүнийг дагаад орон сууц, хүүхдийн цэцэрлэг, сургууль гээд нийгмийн салбарт шийдвэрлэвэл зохиох асуудлууд үүснэ?



-Дорноговь аймаг 2017 оныг "Их бүтээн байгуулалтын жил" болгон зарласныг та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Энэ ажлын хүрээнд их олон ажлыг хийж амжуулаа. Бурхан шашны аяллыг Сайншанд сум руугаа

илүү татах бодлого барин ажиллаж байна. Харин иргэдээ ая тухтай амьдруулахын тулд аймгийн төвд 260 айлын орон сууцны хорооллын барилгын ажлыг эхлүүлсэн. Угсралтын ажил ид явагдаж байгаа. Ирэх

есдүгээр сард ашиглалтад орно. Мөн III, VII багийн нутаг дэвсгэрт орон сууцны иж бүрэн хорооллыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Энэхүү орон сууцны хорооллын үнэ нь зах зээлийн ханшаас хоёр дахин хямд өртөгтэй. Ам.метр нь ердөө нь 650 мянган төгрөг. ЗДТГ тодорхой хэмжээний алагдал хүлээж байгаа ч Дорноговь аймаг ирээдүйд утаанд умбах аюулаас сэргийлж буй юм. Мөн манай хүүхэд, залуучууд тун удахгүй ирэх жилийн өдийд 4D кино театраар үйлчлүүлэх болно. Энэ ондоо багтаан Усан спорт сургалтын төвийн барилгын суурийн ажлыг эхлүүлнэ. Замын-Үүд суманд ч 180 айлын орон сууцны барилгын суурийн ажил эхэлчихсэн байгаа. Дорноговь аймаг улсаас татаас авдаггүй зургаан аймгийн нэг. Тиймээс байгаа нөөц бололцоогоо түшиглэн хөгжих боломж бидэнд бий.

-Дорноговь аймгийн хамгийн том давуу тал нь дэд бүтэц юм. Энэ давуу талаа хэрхэн ашиглаж байна вэ?

-Манай аймаг хамгийнурт авто болон төмөр замтай гэдгээрээ онцлогтой. Энэхүү давуу байдлаа ашиглаад аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Жилд гадны болон дотоодын 95 мянган жуулчин хүлээж авдаг. Одоогоор ийм олон жуулчинг хүлээж авдаг аймаг гэвэл Хөвсгөл, манайх хоёр л байна даа. Гэхдээ манайд дотоодын жуулчид илүү ирдэг. Бидний нэмж хийх ажил бол хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлж, Өвөр Монголын жуулчдыг энергийн төв Хамрын хийд, Хан Баянзүрх уул, Шамбалын орноор зорчуулах юм. Үүнийг дагаад зочид буудал, тээвэр зуучлал, нийтийн хоолны салбарууд хөгжиж, эдийн засгийн эргэлт өснө.

"ДОРНОГОВЬ БАГА ОЛИМП-2017"

"ДОРНОГОВЬ БАГА ОЛИМП-2017" ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Н.БАТЗАЯА

Олимпын үзэл санааг орон нутагт дэлгэрүүлэх, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хүүхэд залуусын бие бялдрыг сайжруулах, ирээдүйн залуу тамирчдыг тодруулах, олимпын наадамд багтдаг топ спортын төрлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулдаг "Дорноговь бага олимп-2017" спортын наадмын

нээлтний үйл ажиллагаа энэ сарын 19-нд Дорноговь аймагт боллоо. Тус наадмын нээлтэд Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзориг, "Рио-2016" олимпын наадмын паралимпийн жүдо бөхийн хүрэл медальт МУТТ Б.Ууганхүү, Самбо бөхийн дэлхийн аваргын мөнгөн медальт, ОУХМ Я.Дорж, "Жюу-жицү" бөхийн дэлхийн гурван удаагийн аварга, жүдо,

самбо, жюу-жицү бөхийн олон улсын хэмжээний мастер О.Болд-Эрдэнэ нарын шилдэг тамирчид оролцлоо. Тэмцээнийг нээж, тус аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг "Спортын Бага олимп маань 2014 оноос эхлэн зохиогдсон бөгөөд "Дорноговь бага олимп" спортын их наадам бидний хувьд нэр хүнд, цар хүрээ өргөнтэй спортын их баяр болсны зэрэгцээ Монгол түмний дараагийн олимпын

аваргыг төрүүлэхэд сэтгэлийн их дэм, тив, дэлхийн тавцанд олон олон амжилт, ялалтуудыг авчрах бэлтгэл болсон томоохон арга хэмжээ болж байгаа гэж ойлгож байна.

Хүн төрөлхтний эв нэгдэл, найрамдлын билэгдэл Олимпизмийн үзэл санааг дэлгэрүүлэн хөгжүүлэх, спортыг сурталчлах, ард иргэдийн эрүүл мэндийг спортын тэмцээн, уралдаанаар дамжуулан дэмжин хамгаалах, бүх нийтийн хүртээл болгоход чухал үүрэг, үлгэр дууриал болж чадаж байгаад Дорноговьчууд та бүхнээрээ бахархаж байна. 2016 онд дэлхий нийтээрээ Бразилийн их олимпын спортын тэмцэлд Монголчууд, тэр дундаа Дорноговьчууд бид паралимпийн анхны медальтнаа өлгийдөн авсан. Магадгүй өнөөдөр та бүхний дундаас дараагийн 2020 оны Токиогийн олимпын амжилт гаргах тамирчид байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Говь нутагт Дорноговь Бага Олимп уламжлал болгон зохион байгуулж байгаад баяртай байна, бахархаж байна.

Төгсгөл нь VIII нүүрт

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Сайншанд сумын хур хогийг цэвэрлэж байна

Н.ЗАЯА

Дорноговь аймаг энэ оныг их бүтээн байгуулалтын жил болгон зарласан. Үүнтэй холбогдуулан Сайншанд сумын хур хогийг цэвэрлэж эхэлжээ. Тодруулбал, тус сумыг Замын-Үүд сумтай холбосон хатуу хучилттай зам дагуу олон жил барилгын хог хаягдал хаяснаас болж хур хог үүссэн байна. Тиймээс Дорноговь аймгийн Тохижилт - Сайншанд хот тохижилтын газраас хур хогийг цэвэрлэх ажлыг эхлүүлжээ. Үүнтэй холбогдуулан тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзориг Тохижилт - Сайншанд хот тохижилтын газрын ажилчидтай уулзаж, тэдний санаа бодлыг сонсохоос гадна халуун хоол, цайгаар дайлав.

Энэ үеэр Тохижилт - Сайншанд хот тохижилтын газрын дарга Б.Жаргалсайханаас зарим зүйлийг тодрууллаа.

-Танай байгууллага 2017-2018 оны зорилгоо хэрхэн тодорхойлсон бэ?

-Манай байгууллага Сайншанд хотын оршин суугчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулахын тулд хог хаягдалгүй, ногоон байгууламжийг бий болгох үүрэгтэй.

Төгсгөл нь VI нүүрт

ЗАР - ЗАР - ЗАР

Төрөл бүрийн мод, бут, сөөг, мандалын цэцэг борлуулж байна. Мөн зүлэгжүүлэлт хийж өгнө.

Хасу мод компани 94009909, 99191366

ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

ММ-ИЙН ТОДРУУЛГА



Сайншанд сумын хур хогийг цэвэрлэж байна

Төгсгөл.
Түрүүч нь V нүүрт

Энэ хүрээнд олон жил хуримтлагдсан хур хогийг сүүлийн гурван өдөр тасралтгүй хүн хүч, тэрэг техникийн хүчээр цэвэрлэхээр ажиллаж байна. Өнөөдөр манай аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзориг бидэнд өдрийн хоол өгч, бидний ажилд дэмжлэг үзүүлээ. Хөдөлмөр хийж байгаа хүмүүст хоол их чухал. Хоол, хүнс сайн бол ажил хийхэд илүү урам зоригтой байдаг. Олон жил хуримтлагдсан хогийг ихэнх нь барилгын чулуу, тоосго байна. Үүнийг ухах гэхээр цаанаас нь бүр их хог гарч ирдэг. Энэ их хогийг цэвэрлэхэд манай машины хүчин чадал төдийлөн сайн хүрэлцэхгүй байна. Ихэнх нь БНХАУ-д үйлдвэрлэсэн “Кама”, “Сонмол” зэрэг машин учраас хог ачихад тохиромж муутай байна. Бид аргаа барахдаа ковшоор бөөгнөрсөн хогийг түрж, тараасны дараа ажилчдаа эгнээгээр явуулж том хогийг нь түүлгэсэн. Үүний дараа дахин машинд ачдаг. Ингэж л зохицуулж байна. Бид дараагийн ээлжинд замын урд талын хогийг цэвэрлэхээр төлөвлөсөн.

“Танай байгууллагын хүчин чадал хүн ам, газар нутагтайгаа харьцуулахад хэр байна вэ. Цаашид боловсон хүчний нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна уу?”

“Манай хот тохижилтын байгууллага үнэхээр өөрсдийнхөө хүч хөдөлмөрөөр л болгож байна. Хүн хүч, машин техникийн хувьд ч нэмэгдүүлэх шаардлагатай. Учир нь манай байгууллага ногоон байгууламж, хог зөөвөр, гэрэл гэрэлтүүлэг, зам талбай, аялал жуулчлалын чиглэлд үйл ажиллагаа явуулдаг учраас бүх л зүйлд оролцдог. Хүн хүч бага болохоор нөгийг нь нөгөө рүү нь шилжүүлээд л явдаг.

“Санхүү, төсөв жилийн хэрэгцээнд хүрэлцэж байна уу?”

“Хуваарилганд төсөв болохын хувьд болж байна. Гэхдээ төсөв хөрөнгө огт дутагдалгүй байна гэж үгүй шүү дээ. Байгаа төсвөө бид аль болох аж ахуйн аргаар болон нөөцдөө тулгуурлан зохицуулаад л явж байна. Мөн манай ажилчдын нийгмийн асуудалд онцгой анхаарах үйл олон бий. Тухайлбал, манай ажилчдын өдрийн хоол, унааны мөнгийг төсвийн тодотгоор хасагдчихсан. Үүнийг анхаарч, ядаж өдрийн хоолных нь мөнгийг эргүүлэн олгоосой гэж их болдог юм. Гэхдээ манай МИХ-ын гишүүн, аймаг орон нутгийн удирдлагууд биднийг их ойлгож, дэмждэг. Хамтын ажиллагаатай байдал нь баярлаж явдаг.



МЭДЭЭЛЭЛ

Франц эмч нар үнэ төлбөргүй үзлэг, мэс засал хийнэ

Франц улсын нүдний нарийн мэргэжлийн эмч нар Дорноговь аймгийн Сайншанд хотод энэ сарын 28-аас зургадугаар сарын 7 хүртэл ажиллахаар болжээ. Франц улсын нүдний эмч Рене Жан Клод ахлагчтай дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй баг иргэдэд нүдний болор суулгах юм байна. Харин нүдний болор суулгах мэс засалд орох хүмүүсийг тус аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний эмч нар үзлэг хийсний дүнд сонгох гэв. Одоогийн байдлаар болор суулгах 10 орчим хүн байгаа гэж албаныхан хэллээ. Мөн франц эмч нарын Улаанбаатараас ирэх зардал, Сайншандад байрлах буудал, хоолны зардлыг аймгийн ИТХ, ЗДТГ хариуцахаар болсон аж. Харин нүдний эмч нарын дараа

"Action Mongolia" нийгэмлэгийн Ерөнхийлөгч, мэс заслын эмч Jacques Lagoutte ахлагчтай долоон хүний бүрэлдэхүүнтэй баг Сайншандад ирж тус аймгийн иргэдэд нарийн мэргэжлийн үзлэг болон дурангийн мэс заслыг үнэ төлбөргүй үзүүлэхээр болжээ. Түүнчлэн гадаад эмч нар хэвлийн хөндийн нарийн мэргэжлийн үзлэг хийж, шаардлагатай хүмүүст дурангийн мэс засал хийх юм байна. Харин тус аймгийн нэгдсэн эмнэлэг дурангийн мэс засал хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжтэй болсон хэдий ч ариутгал хийх боломжгүй байгаа аж. Ариутгалыг хамгийн бага температурт тусгай хийгээр үзлэгжж ариутгадаг хэмээн холбогдох мэргэжилтнүүд тайлбарлалаа.

ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-2017

Б.Цэнд-Аюуш:

Н.БАТЗАЯА

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, газрын бодлого хариуцсан тэргээжилтэнтэй уулзаж, газрын ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар ярилцлаа.

“Аливаа хөгжилт цэцэглэлт ерөнхий төлөвлөгөө түүнийг үндэслэж гаргасан газар зохион байгуулалтын асуудлаас эхлэх ёстой болов уу.”

–Дорноговь аймгийг 2016-



ДОРНОГОВИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ ДУУССАН

2020 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго иргэдийнхээ ая тухтай, эрүүл, аюулгүй, цэвэр гэрэлтэй, аюулгүй, цэвэр орчинд ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Ер нь бол дорноговьчууд “Хөгжлийн төлөв хамтдаа” уриан дор хамтдаа хөгжиж дэвхэх учиртай. Дорноговь аймгийн хөгжлийн үндэс суурь нь бүтээн байгуулалт шүү дээ. Хэдийгээр улс орны эдийн засагын нөхцөл байдал хүндхэн байгаа ч бидэнд ашиглаж чадах аваас амжилтад хүрэх давуу тал бий. Дэд бүтэц гэхэд бүхий л талаараа хөгжсөн байх жишээний. Мөн манай улсын хамгийн том боомт болох Замын-Үүд, Ханги байна. Дээр нь манай аймаг гадаад харилцаагаар маш сайн хөгжүүлж чадсан. Үүний үр дүнд жилээс жилд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж буй. Мөн байгалийн баялаг, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гээд эдийн засаг талаасаа ихээхэн тус нэмэр болох салбарууд боломжийн түвшинд хөгжсөн гээд боломж байгаа. Нөгөөтэйгүүр, газар бол хөгжлийн үндэс суурь нь. Аливаа бүтээн байгуулалтын мөн чанар газрын хуваарилалт хэр оновчтой вэ гэдгээс ихээхэн шалтгаална. Энэ утгаараа “Хөгжлийн төлөв хамтдаа” хөтөлбөрийн үр дүн газарт суурилсан төлөвлөлтийг ажил хэрэг болгох явдал юм. Бид аймгийнхаа нийт нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ойрын үед боловсруулна. Ингэхдээ газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ дээр суурилна. Өөрөөр хэлбэл, тухайн газарт нийгэм, эдийн засгийн, усны, хөрсний, экологийн гэх мэтчилэн маш олон төрлийн судалгааг хийсний үндсэн дээр ямар зориулалтаар ашиглавал тохиромжтой юм бэ гэдгийг тодорхойлж улмаар төлөвлөлтүүдээ хийнэ.

Жишээ нь, орон нутгийн иргэд цэцэрлэг байгуулах санал гаргаж, газрыг нь зааж өгсөн байлаа гэж бодоход тухайн газар нь хөрснийхөө хувьд цэцэрлэг барихад тохиромжтой юу, эдийн засаг талаасаа хэчнээн хүүхэд сурч хүмүүжих вэ гэх тухайд бидний хийсэн судалгааг үндэслэх учиртай. Ийм байдлаар газарт суурилсан төлөвлөлт, байршил, дэд бүтэц гээд хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох юм.

“Ирэх дөрвөн жилд өрнүүлэхээр төлөвлөсөн бүтээн байгуулалтаас аль нь ажил хэрэг болж байгаа вэ?”

–Аймгийн Засаг даргын захирамж гарган 2017 оныг их бүтээн байгуулалтын жил болгон зарласан. Энэ ажлын хүрээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, түүнийг даган орж ирэх гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах асуудалд онцгой анхаарал хандуулж буй. Харин ирэх дөрвөн жилд өрнөх их бүтээн байгуулалтыг иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлаж төлөвлөгөөгөө гаргасан гэдгийг онцлон хэлэхийг хүсч байна. Бид хамгийн нэгдүгээрт нийгмийн талаар тодруулж хэлэхэд, манай аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “Дорноговь хөгжлийн сан”-д төвлөрүүлсэн хөрөнгөөс 1.8 тэрбум төгрөгөөр нь дээр төвийг барихаар болсон юм. Суурийн ажил нь удахгүй эхэлнэ. Үүнтэй зэрэгцээд хүүхэд залуучуудынхаа сурч

боловсроход нь зориулж, усан спорт сургалтын төвийн хуучин барилгыг нурааж шинээр барихаар болсон. Мөн 4D кино театр барих, цэцэрлэгт хүрээлэнгээ засч, тохижуулах, төв талбайн их засварын ажил залгах учиртай. Энэ онд эхлүүлсэн томоохон хэмжээний бүтээн байгуулалтууд 2019 онд бүрэн дуусч улсын комисст хүлээлгэж өгөхөөр төлөвлөсөн гээд хөгжлийн цаашдын чиг хандлагыг гэрэл зорилготой бүлэг рүү чиглүүлсэн 1000 айлын орон сууцны “Мандах наран” хорооллууд. Хамгийн гол нь иргэдийн худалдан авах чадварт нийцүүлэх нь бидний зорилго. Тэр хүрээнд Замын-Үүд суманд 260, аймгийн төвд 780 айлын орон сууц баригдана. Эхний ээлж нь 2017 оны намар ашиглалтад орно. Барилгын ажил эхлээд удаагүй байгаа ч явц нь маш сайн байгаа. “Мандах наран-2” хорооллыг ЕБ-ын нэгдүгээр сургууль, Автотээврийн үндэсний төвийн хажууд баригдаад эхэлсэн. Удахгүй долдугаар багийн нутаг дэвсгэрт баригдах 260 айлын орон сууцны хорооллын суурийн ажлыг эхлүүлнэ. Бүгдийнхэнд бүтцийн асуудал нь шийдэгдсэн. Мөн төрийн үйлчилгээг иргэдэд ойрхон хүргэхийн тулд зургадугаар багийн нутаг дэвсгэрт “Иргэдийн хөгжлийн төв” барина. Барилгын ажил нь эхэлсэн. Алтанговийн өмнөх талбайг засварлах ажил Эрэн хотын хөрөнгө оруулалтаар иргэдэнд хийгдэнэ. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг бүрэн шинэчилж, одоо ашиглагдаж байгаа нь гэр хороололд тавьж, наймдугаар сард ашиглалтад хүлээлгэж байна

“Их бүтээн байгуулалт сумдын хөгжил рүү ямар байдлаар чиглэгдэж байгаа бол?”

–Сум орон нутгийн тухайд

тухайн сум маань ямар онцлогтой, ямар давуу талтай түүнд нь суурилан хөгжлийн загварыг боловсруулах ажлууд хийгдэж байгаа. Дорноговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө өнгөрсөн оны арванхоёрдугаар сард батлагдсан. Газрын ерөнхий төлөвлөгөөг хөдөө аж ахуйн газар, авто зам, инженерийн шугам сүлжээ, аялал жуулчлал, хот суурин гэсэн чиглэлээр боловсруулсан. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу сум орон нутгийг хөгжлийн ерөнхий төлөв байдлыг тодорхой болгосон.

“Замын-Үүд хөгжил цэцэглэлт муутай гэх шүүмжлэлд байнга өртөж байдаг. Ялангуяа бие засах газрын асуудал. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд шинэ Замын-Үүд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үү?”

–Гурван улсын уулзалт мөн түүнчлэн Эрэн хоттой байгуулсан хамтын ажиллагааны гэрээ “Харилцан ашигтай хамтран хөгжье” уриан дор зохион байгуулагдсан. Энэ хүрээнд тодорхой ажлууд хийгдэж байгаа. Замын Үүд боомтыг хөгжүүлэх асуудал ЗДТГ-ын анхаарлын төвд байдаг. Хил гаалийн түргэн шуурхай ажиллагаа, 00 асуудалд би анхаарлаа хандуулж байгаа. Эрэн хотынхон манайд био 00 өгөхөөр болсон. Хилээр орж ирж байгаа байх. Бие засах газрын асуудал зөвхөн Замын-Үүд ч биш Хамрын хийд болон аймгийн төвд ч шаардлагатай зүйлийн нэг. Мөн Замын-Үүдэд хог дахин боловсруулах үйлдвэрийг Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар барихаар болсон. Ер нь бид өмнөхөөсөө илүү хүний нүдэнд харагдахуйц ажлуудыг эхлүүлээд байгаа шүү.

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: 72 дугаар цэцэрлэгийн гадна фасад, барилгын засвар /Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо/-ын ажил

Тендер шалгаруулалтын дугаар:
НХААГ-17/0142

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендер оролцогчдоос 72 дугаар цэцэрлэгийн гадна фасад, барилгын засвар /Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй

татаж авна уу.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /Гавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн саналын 30 хувиас багагүй байна;

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн

тоо: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он;

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн нийт төстэй ажлын өртөг: 2015, 2016 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийж гүйцэтгэсэн байх;

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,

Тендерийн хамт 1 000 000 /Нэг сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байшдуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн, 09 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх:
Оролцох эрхгүй

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: Тооцно.

Сонифхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар Холбоо барих утасны дугаар: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

Орон нутгийн хөгжилд СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЧУХАЛ ГЭВ

Б.ЛХАГВАСҮРЭН

“Соёлын үйлдвэрлэл орон нутгийн хөгжилд” зөвлөлдөх уулзалт энэ сарын 19-нд Дорноговь аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхимд боллоо. Тус зөвлөгөөнийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар болон Дорноговь аймгийн соёл, урлагийн газар хамтран зохион байгуулав. Энэ үеэр Дорноговь аймгийн БСУГ-ын соёл, урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Хүдэрчулуун “Бид улсын зөвлөгөөний өмнө соёл урлагийн ажилтны аймгийн нэгдсэн зөвлөгөөнөө хийж байна. Энэхүү зөвлөгөөнд нийт 14 сумын соёл, урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож байна. Бид зөвлөгөөн гэхээс илүү сургалтын хүрээнд зохион байгуулж байгаа. Учир нь салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тэдэнд мэдээлэл өгөх зорилготой. Мөн салбарынхаа тулгамдаж буй асуудлыг ярилцаж, цаашид хэрхэх талаар ч хэлэлцүүлэг өрнүүлнэ” гэв. Зөвлөгөөн хоёр үе шаттайгаар үргэлжилсэн бөгөөд нийт 150 гаруй соёл, урлагийн ажилчин оролцсон юм. Зөвлөгөөний эхэнд соёл, урлагийн ажилчдад зориулан чадавхжуулах, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Харин хоёрдугаар шатад зөвлөгөөнд оролцогчдыг чиглэл тус бүрээр нь хуваан тодорхой асуудлын хүрээнд хэлэлцүүлэг



өрнүүлээ. Хэлэлцүүлгийн үеэр орон нутагт соёл, урлагийн салбарыг хөгжүүлэхийн тулд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэдгийг салбарынхан онцолж байв. Энэ үеэр Ихэт сумын Соёлын төвийн эрхлэгч С.Мөнхжаргал “Соёлын салбарын ажилтнууд чадавхтай, чадвартай байж хүнийг хөгжүүлж, нийгмийг өөрчилдөг. Гадаадын улсын жишээнээс харахад, соёлын салбар нь үргэлж нэгдүгээрт байдаг. Гэтэл Монгол Улсад соёлын үйл ажиллагаа маш доогуур тавигддаг. Энэ нь Монгол Улс хөгжихгүй байгаагаар холбоотой. Соёлын салбарт ажиллаж буй хүмүүсийг чадавхжуулах талаар соёл, урлагийн байгууллага, СУИС ажиллаж байна. Гэхдээ энэ чиглэлээр төгссөн хүмүүсийг хөдөө орон нутагт ажиллах нөхцөл боломжор хангадаггүй учраас



соёлын салбар уналтад байгаа юм. Сайхан дуулаач, соёлын менежер төгсөөд хөдөө орон нутагт ажиллаж гэхээр ажлын байр байдаггүй. Ажлын орчин нөхцөлийг нь бүрдүүлэггүй болохоор ажиллах хүн олддоггүй. Ялангуяа хөдөө орон нутагт хүний нөөцийн асуудал чухал байр суурь эзэлж байна. Манай Дорноговь аймагт соёлын ажилчид байгаа хэдий ч тэдний нийгмийн асуудлыг шийдэж өгөөгүй учраас тогтвор суурьшилтай ажиллах, Соёлыг үйлдвэрлэх, бүтээхэд томоохон саад учирдаг. Хот болон хөдөө

орон нутаг соёлын зөвлөгөөн олон зохион байгуулагдаж байсан. Гэхдээ төрийн өөрчлөлтөөс соёлын ажлыг унагаад байна. Соёл, аялал жуулчлалын яамыг байгуулахад бидих баярласан. Гэвч татан буулгачихсан. 76 гишүүнээс ганцхан хүн л дэмжсэн. Соёлын салбар хөгжихгүй бол Монгол Улс хөгжихгүй. Сүүлийн үед энэ талаар хүмүүс ярьж, хэлж байна” гэсэн юм. Харин Улаанбадрах сумын соёлын төвийн эрхлэгч Ч.Цэцэгмаа “Манай Улаанбадрах сумын Соёлын төв нийт долоон ажилчинтай. Төсөв санхүүгийн

хувьд ажилчдын цалингийн сан хуралцдаггүй учраас их хүндрэлтэй байдаг. Харин Соёлын төвийн барилга өнгөрсөн 2014 онд их засварт орсон. Соёл урлагийн тоглолт хийхэд дутагдах зүйл байхгүй болсон. Гэхдээ орон нутагтаа соёлын үйл ажиллагаа явуулахад төсөв, санхүүгийн хүрэлцээ муу байдаг.

Түүнээс гадна боловсон хүчний асуудал байна. Хөдөө орон нутагт тэр дундаа суманд мэргэжилтэн ажиллуулаа гэдэг их хүндрэлтэй. Тэдний цалин хөлс, ажлын орчин, нийгмийн асуудлаас эхлээд олон асуудлыг бүрэн шийдвэрлэж чаддаггүй. Боловсролын байгууллагын ажилчид гэхэд таван жилийн нэмэгдэл авч байхад соёлын салбарынханд нийгмийн талын баталгаа алга. Үүнтэй холбогдуулан хүмүүс ажилдаггүй. Тиймээс энэ талаар ч гэсэн анхаарах хэрэгтэй. Бид сэтгэл зүрхээрээ сум багийнхаа иргэдэд соёлын үйл ажиллагааг түгээж байна. Тухайлбал, манай соёлын төвийн ажилчид гурван багийнхаа өдөрлөгийн үеэр урлагийн тоглолт үзүүлж, номын үзэсгэлэн гаргалаа. Мөн сургуулийн сурагчдын дунд бяцхан ном хийх уралдаан зарласан. 2017 онд “Сэтгэлээс урсах аялгуу” зохиолын дууны тэмцээнийг нийт ардын авьяастнуудын дунд зохион байгуулсан. Энэ мэтчилэн соёл урлагаар дамжуулан ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд уриалж байна” гэв.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Хотыг тохижуулах аян үргэлжилж байна

Сайншанд сумын ЗДП-аас санаачилж хотын өнгө үзэмжийг сайжруулах, тохижилт үйлчилгээг нэмэгдүүлэх, хотдоо сайхан амьдрах зорилгоор зохион байгуулж байгаа “Тэгш гудамж”, “Хотын гудамж”, “Хамтдаа тохижуулах” аян амжилттай үргэлжилж байна. Аяны хүрээнд бизнес эрхлэгчдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, аж ахуй нэгжүүдийн эзэд болон хотын иргэдтэй уулзаж хотын өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж буй. “Хотын гудамж” аяны хүрээнд Сайншанд сумын төв гудамж дагуу “Эргэл” худалдааны төвийн гаднах талбайг тохижуулж, явган хүн, авто машины орох, гарах гарцыг тодорхой болгож тохижуулж байна. Мөн УБТЗ-ын “Ган зам”, Шашны дэлгүүр, “Мөнхдүүрэн”, “Сувдан-Өргөө” зэрэг худалдааны төвүүд гаднах талбайгаа тохижуулах бол нийтийн бие засах газрыг ашиглалтад оруулж, гаднах хашиаг нь буулгаж цэгцлэхээр болжээ. Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй “Хас”, “Монголбанк”, “Худалдаа хөгжлийн банк”, “Хаан” “Голомт” зэрэг банкууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд



гаднах талбайн өнгө үзэмжид анхаарч тохижуулах аж. “Шинэ зуун” худалдааны төв гаднах машины зогсоолоо шинэчилсэн байна. “Тэгш гудамж” аяны хүрээнд Сайншанд хотын хойно байдаг хөтлийн замын хоёр талын гэр хорооллын айл өрхийн нүүрний гудамжийг тэгшилж, нэгэн ижил өнгө будганд оруулахаар ажиллаж байна. Түүнчлэн Төмөр замын хэсгийн “Оргил”, “Наран” худалдааны төв, төмөр замын дагуух байрнуудын айл өрхүүд харьяалах багийн Ажлын албатайгаа хамтран орон сууцныхаа өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр ажиллаад эхэлжээ. Албаныхан “Хамтдаа тохижуулах” аяны хүрээнд барилгын компаниуд болон барилгын дэлгүүрүүдтэй хамтарч ажиллаж байна. Төв цэцэрлэгт хүрээлэн болон аймгийн Шүүхийн барилгын урд буй Сайншанд сумын VI багийн нутагт байрлах “Залуус” цэцэрлэгт хүрээлэнг орон нутгийн барилгын компаниуд болох “Тобэм” ХХК, “Энержи парагон” ХХК, “Айсуй хөгжил” ХХК, “Нэгдсэн Монгол” ХХК өөрсдийн хөрөнгөөр иж бүрэн засварлаж өгөхөөр болов. Мөн “Хул Шанд”, “Үлэмж”, “Сувдан-Өргөө” “Их говийн өргөө”, “Сангийн далай” зэрэг барилгын дэлгүүрүүд барилгын материалаар дэмжиж ажиллаж юм. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэнг тохижуулахаар төлөвлөн дээрх аянд МСУТ-ийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид оролцохоор боллоо. Мөн МСУТ-ийн мужааны ангийн оюутнууд, “Модны зах”-ын эзэд Сайншандын ар хөтөл дээр байх “Дорноговь 80” цогцолборыг тохижуулахад оролцоно.

Найман “Шилдэг гэр бүл”-ийг шалгаруулав

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны есдүгээр сарын 20-нд нэгэн хэлэлцээр хийсэн нь хүн төрөлхтний түүхэнд гэмдэглэн өнгөрүүлэх томоохон үйл ажиллагааны нэг болон өргөжсөн билээ. Тус хэлэлцээрээр 1994 оноос эхлэн жил бүрийн тавдугаар сарын 15-ны өдрийг “Гэр бүлийн өдөр” болгон тэмдэглэж байх тогтоолыг баталсан байдаг. Тэгвэл энэхүү өдрийг тохиолдуулан Дорноговь аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, болон Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “Шилдэг гэр бүл”-ийг алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулсан аж. Ёслолын үйл ажиллагаанд Дорноговь аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Байгалтуяа, аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга П.Долгорсүрэн болон холбогдох албаны хүмүүс оролцож, шилдэг гэр бүлүүдэд шагнал гардуулсан байна. Тус аймгийн 2017 оны “Шилдэг гэр бүл”-ээр Айраг сумаас Б.Баасандоржийн гэр бүл гэргий Г.Алтанцэцэг нар, Алтанширээ сумаас С.Сумъяагийн



гэр бүл гэргий Б.Ариунаа нар, Дэлгэрэх сумаас Ч.Дорждэрэм гэр бүл гэргий Н.Энхмөнх нар, Замын-Үүд сумаас Д.Товуугийн гэр бүл, гэргий Я.Цэрэндаш нар шалгарчээ. Харин Улаанбадрах сумаас Н.Цэвэгмэд гэр бүл гэргий Д.Жавзандулам нар, Эрдэнэ сумаас Ж.Баярсайхан гэр бүл гэргий Л.Сарангэрэл нар, Я.Галсангийн гэр бүл гэргий Т.Алтанцэцэг нар, Хатанбулаг сумаас А.Гантөмөр гэр бүл гэргий Л.Цэвэлмаа нарын гэр бүл тус тус шалгарлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад 1000 гаруй хамрагджээ

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт энэ сарын 17, 18-нд Замын-Үүд, Эрдэнэ суманд боллоо. Тус сургалтыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, түүний гаралтыг бууруулах зорилгын хүрээнд Дорноговь аймгийн Цагдаагийн газар,

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс хамтран зохион байгуулжээ. Сургалтад тус аймгийн Цагдаагийн газрын дэд даргаар Б.Ганцоожоор ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны баг Замын-Үүд, Эрдэнэ сумдын төрийн албан хаагч, сумын эмнэлэгийн эмч, сувлагач, сургууль, цэцэрлэгийн багш, сурагчид хамрагджээ. Мөн Хилийн 0129 дүгээр ангийн алба хаагч, Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэсгийн албан хаагч зэрэг нийт 1000 гаруй хүн оролцож, хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр.
Тендер шалгаруулалтын нэр: “Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийн 2 байрны дээвэр болон гадна дулааны шугам сүлжээний засвар /Баянгол дүүрэг, 8 дугаар хороо/-ын ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0134

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос “Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийн 2 байрны дээвэр болон гадна дулааны шугам сүлжээний засвар /Баянгол дүүрэг, 8 дугаар хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн саналын 30 хувиас багагүй байна;

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он;

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийж гүйцэтгэсэн байх;

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 1 000 000 /Нэг сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 08 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох

хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн, 09 цаг 00 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: Оролцох эрхгүй

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар Холбоо барих утасны дугаар: 75757807 Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

“ДОРНОГОВЬ БАГА ОЛИМП-2017”

“Дорноговь бага олимп-2017” ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Төгсгөл.
Түрүүч нь V нүүрт

Энэхүү спортын наадамдаа амжилттай оролцож, эрч хүчтэйгээр сум, багаа төлөөлөн шударгаар өрсөлдөж, олон түмний сэтгэл тэнийсэн сайхан арга хэмжээ болно гэдэгт итгэл дүүрэн байна. Ингээд “Дорноговь бага олимп 2017” спортын наадам албан ёсоор нээснийг сонордуулъя. Дорноговьчууд та бүхэндээ эрүүл энх, аз жаргалыг хүсч, нийт баг тамирчиддаа шударга өрсөлдөөний талбар болох спортын дэвжээнд амжилт, ялалт дүүрэн байхын ерөөлийг өөд өөд нь өргөн дэвшүүлье” гэв. Хоёр жил тутамд нэг удаа зохион байгуулагдах энэхүү спортын наадам нийт есөн төрөлд болов. Тодруулбал, орс таталт, 100 буудалт даам, сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, аэробек, үндэсний бөх, шатар, хөнгөн атлетик зэрэг есөн төрлөөр тамирчид хурд хүч самбаагаа сорин өрсөлддөө. Мөн нээлтийн үйл ажиллагааны үеэр 2016 оны Бразилын Рео де



“Дорноговь-бага олимп”-ийн наадмын нийлбэр дүнгээр тэргүүн байрт Сайншанд сумын баг тамирчид, дэд байрт Айраг сумын баг тамирчид, гутгаар байрт Замын-Үүд сумын баг тус тус шалгарсан юм. Энэ үеэр бид зарим тамирчин, дасгалжуулагчтай уулзаж, ярилцлаа.

Б.Ууганхүү:Олимп бол ЭВ НЭГДЛИЙН НААДАМ

/Паралимпийн жүдо бөхийн хүрэл медальт, МУТТ/

“Рио-2016” олимпын наадамд хойш багагүй хугацаа өнгөрсөн байна. Намайг нутгийн минь зон олон маш сайхан хүлээж авсан. Өнөөдөр манай аймагт бага олимп зохион байгуулагдаж байгаад маш их баяртай байна. Учир нь олимпын наадам гэдэг эв нэгдлийн бэлгэ тэмдэг болсон маш том үйл ажиллагаа байдаг. Энэхүү том спортын наадмын есөн төрлийн тэмцээн нутагт маань болж байна. Тэмцээн дөрвөн өдрийн турш үргэлжиллээ. Тиймээс нийт тамирчиддаа амжилт хүсье.

Я.Дорж:Залуусын оролцоо жил ирэх тусам нэмэгдэж байна

/Самбо бөхийн дэлхийн аваргын мөнгөн медальт, ОУХМ/

Олимпын бага наадам өмнө нь нэг удаа зохион байгуулагдсан. Тухайн үед хүмүүсийн оролцоо бага байсан. 2016 он Дорноговьчуудын хувьд түүхэн жил боллоо. Учир нь “Рио-2016” олимпын наадамд Б.Ууганхүү хүрэл медаль авч, аймагтаа анхны гавьяат тамирчин хэмээх эрхэм алдрыг авч ирсэн. Үүнтэй холбогдуулан энэ жил бага олимпын зохион байгуулж байгаа. Ер нь Дорноговь аймгийн Тамгын газар, ИТХ-аас мөрийн хөтөлбөртөө хоёр жилд нэг удаа бага олимпын зохион байгуулахаар тусгасан. Энэ удаагийн бага олимпын наадамд тамирчид маш сайхан өргөн бүрэлдэхүүнтэй оролцож байна. Бүх нийтээр спортоор хичээллэснээр бие бялдарын хөгжилд сайнаар нөлөөлнө. Мөн эмтэй эмчлэгээг халах сайн нөлөөтэй. Хөдөө орон нутагт спортыг хөгжүүлэхэд дутагдалтай тал их бий. Хөрөнгө мөнгөний асуудал гарч ирнэ. Спортын хэрэглэл, материалын асуудал ч яригдана. Манай Дорноговь аймагт дэд бүтэц их сайн хөгжсөн. МУСМ А.Зоригтбаатар, Дорноговь аймгийн Айраг сумын биений тамирын багш, сумын заан Э.Ариунбаяр, Дорноговь аймгийн БТСГ-ын боксын дасгалжуулагч Ж.Баяр-Отгон нарыг тус тус шагнаж урамшуулсан юм. Ийнхүү дөрвөн өдрийн турш үргэлжилсэн



Женерогийн Паралимпийн жүдо бөхийн хүрэл медальт, МУТТ Б.Ууганхүү олимпын бамбарыг асааснаар тэмцээн албан ёсоор эхэлсэн юм. Энэ удаагийн тэмцээнд 12 сумын 800 гаруй тамирчин дөрвөн өдрийн турш өрсөлдөж, шилдгүүдээ тодруулсан юм. Энэ үеэр “Дорноговь бага олимп-2017” спортын наадмын ерөнхий шүүгч, БТСГ-ын сагсан бөмбөгийн дасгалжуулагч, ерөнхий шүүгч Н.Сугарбаатар “Манай аймгийн

Засаг даргын мөрийн хөтөлбөрт бага олимп зохион байгуулах тухай тусгасан байдаг. Энэ хүрээнд бага олимпын наадмыг Биений тамир, спортын газартай хамтран зохион байгуулж байна. Бага олимп нийт есөн төрөлд болно. Спортын төрөл бүрт мэргэжлийн шүүгчид бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна. Олимп гэдэг хүн төрөлхтөн улс төр, шашин шүтлэг хамаарахгүйгээр эвлэлдэн нэгддэгийн бэлгэ тэмдэг байдаг. Тиймээс орон нутагт нийтийн

ӨӨРӨӨС НЬ

Л.Баатар: ЗАЛУУС ЦЭРГИЙН АЛБА ХААХ СОНИРХОЛТОЙ БОЛСОН БАЙНА

Н.ЗАЯА
Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн хэлтсийн дарга, хурандаа Л.Баатартай цөөн хором ярилцлаа.

–Жил бүр орон даяар цэрэг татлагын үйл ажиллагаа өрнөдөг. Энэ жилийн цэрэг татлагын онцлог юу байв?
–Дорноговь аймгийн цэргийн штаб Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын бүрэлдэхүүнд багтаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Манай байгууллагын гол онцлог гэвэл орон нутагт батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, аймгийн Засаг дарга болон БХЯ-ны сайдын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээг хэрэгжүүлж ажиллах үндсэн чиг үүрэгтэй. Дээрх үүргүүдийн нэг нь ард иргэдэд батлан хамгаалах хууль тогтоомжийг

сурталчлах, иргэдэд цэрэг эх оронч хүмүүжил олгох зэрэг олон талт үйл ажиллагаа юм. Мөн цэрэг татлагатай холбогдуулан цэргийн тоо бүртгэлийг хөтлөх, дайчилгааны сургалт, бэлтгэлийг зохион байгуулах, цэрэг халалт, таталт гэх мэтчилэн үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна. 2017 оны гуравдугаар сард Монгол цэргийн өдрөөр Зэвсэгт хүчний 94 жилийн ойн баяр тохиосон. Энэ хүрээнд аймгийн Засаг даргын захиралжаар 15 ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тухайлбал, Дорноговь аймагт бэлтгэл болон чөлөөнд байгаа үндэсний аюулгүй байдлыг хангасан тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, цэргийн тэтгэвэрт гарсан хүмүүсийн “Мөнхийн мөрдөстэй залуу нас” сэдэвт ажлыг аймгийнхаа Ахмадын хороотой хамтарч зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд 110 орчим ахмад

настан оролцсон. Энэ хүмүүсийн хичээл зүтгэлийг үнэлж шагнаж, урамшуулсан. Мөн Дорноговь аймгийн ЗДТГ-тай хамтарч 18 нас хүрсэн залуучуудад цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулах ажлыг зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаанд 40 орчим залуус оролцлоо. Уг үйл ажиллагааны үеэр Замын-Үүд сумын Хилийн 014 дүгээр ангид алба хааж байгаа цэргүүд ая дууны мэндчилгээ хүргэсэн. Зэвсэгт хүчний 94 жилийн ойтой холбогдуулан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүрэг дүнд болдог “Марш тактикийн тэмцээн”-ийг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаатай уялдуулан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүрэг үүрэг бүхий байгууллагуудын дунд орон нутагт болзошгүй аюул занал тохиолдсон үед хэрхэн ажиллах талаар команд штабын нэгдсэн

дадлага, сургуулилтыг хийсэн. Дадлага, сургуулилтаар бүх байгууллага үндсэн чиг үүрэгээ гадна болзошгүй үймээн, самуун үүссэн үед хэрхэн хамтарч ажиллах талаар нэг ойлголцолд хүрсэн үр дүнтэй үйл ажиллагаа болсон.
–**Нэг үе цэрэгт алба хаахаар ирсэн залуус бичиг үсэг тайлагдаагүй байдаг байлаа. Сүүлийн үед төрийн албанд зүтгэх сонирхолтой залуус алба хаахыг хүсэх болсон. Энэ жил хугацаат цэргийн алба хаахаар ирсэн залуусын боловсрол, мэдлэг ямар байна вэ?**
–Батлан хамгаалах яамнаас батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлах талаар орон нутагт олон ажил зохион байгуулж байна. ЕБС-ийн ахлах ангийнхны дунд спортын “Дөл” тоглолтыг зохион байгуулдаг. Энэ жил манай аймгийн ахлах 12 сургуулийн найман баг оролцсон.



Тус тэмцээнд Зүүнбаян сумын сургуулийн ахлах ангийн сурагчид тэргүүн байр эзэлсэн. Эндээс харахад, цэрэг, эх оронч үзлийг залуучуудад суулгах хандлага өөрчлөгдөж байна. Ялангуяа төрийн албанд цэргийн алба хаасан хүмүүсийг ажилд авахтай холбогдуулан залуучууд цэрэгт явах болсон. Ер нь залуучуудын ихэнх нь цэргийн алба хааж өөрийгөө сорих, эх орноо батлан хамгаалах хандлагатай болсон байна.
–**Цэрэг татлагыг ихэвчлэн хаанаас татав. Орон нутаг эдийн засгийн үр ашгаа бодоод ойролцоох аймгуудаас**

татдаг уу. Энэ талаар салбар яамнаас ямар бодлого барьдаг юм бэ?
–Дорноговь аймаг цэрэг татлагын ажлыг хоёр бүсчлэлд явуулдаг. Энэ жил Даланжаргалан, Ихэт, Дэлгэрэх, Алтан ширээт, Замын-Үүд зэрэг сумын залуучуудын дунд цэрэг татлага зохион байгуулсан. Цэргийн албанд татагдаж байгаа 18-26 насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг. Үүнээс хархад дотор, мэдрэлийн чиглэлийн өвчлөл залуучуудын дунд өндөр байна. Бид эрүүл мэндээ сайжруулах талаар үнэтэй зөвлөгөө өгдөг.